

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: БНА-2023/19-3-ШТА-ГА

Баянхонгор хот 2023 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор Н.Батчимэг

Утас: 91113253 цахим хуудас: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/10

Номгон

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" (БНА-2023/19-3-ШТА-ГА кодтой) сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат, Засаг дарга Д.Мөнхсайхан, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэгт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Должмаа)-д даалгасугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг Баянхонгор аймгийн ЭМГ-ын дарга (Н.Энхжаргал), аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр гүйцэтгэгч (Ч.Жавзан), аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Оюунжаргал), аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч (Б.Азжаргал)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Б.Должмаа), аудитор (Н.Батчимэг) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (А.Цээням), ахлах аудитор (Б.Должмаа), аудитор (Н.Батчимэг)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

005010027



АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 3

БҮЛЭГ Б.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ТАСАРСАН, САНХҮҮЖИЛТИЙГ ХЯНАЖ, ХАСАГДЛЫН ДҮНГ ЭХ ОЛОНЛОГТ НОГДУУЛАН ХАСЧ БАЙГААГААС ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД САНХҮҮГИЙН АЛДАГДАЛД ОРОХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА. 5

Б1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2022 онд үндэслэлгүй төлөвлөсөн, эрүүл мэндийн даатгалыг иргэдэд сурталчлах ажил хангалтгүйгээс орлогын төлөвлөгөө биелээгүй байна. 5

Б1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянасан боловч нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр сар бүр тайлан гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээгүй, санхүүжилтийг журамд заасан хугацаанаас хоцроож олгосон байна. 7

Б1.3. Баянхонгор аймагт эрүүл мэндийн салбарт ажиллах хүний нөөц дутагдалтай, аймгийн ЭМДХ баталсан орон тоогоор ажиллахгүйгээс цаашид санхүүжилтийг хянахад эрсдэл үүсэхээр байна. 9

Б1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэмэлт сонгон шалгаруулалтад хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүрээнд иргэдэд үзүүлэх боломжтой оношны хамаарлын бүлгийг нэмээгүйгээс иргэдэд олгох боломжтой эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж чадахгүй байна. 12

Б1.5. ЭМДЕГ-тай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээг тухай бүр дүгнээгүй байна. 13

Б1.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор баталсан тусламж үйлчилгээний суурь ертгийн тариф, итгэлцүүрийг зах зээлийн үнэ ханштай уялдуулан шинэчлэхээр байна. 14

БҮЛЭГ Б.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ТОДОРХОЙ АХИЦ ДЭВШИЛ ГАРСАН БАЙНА. 21

Б2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд иргэдэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч аймгийн ЭМГ, НДХ, ЭМДХ, Нэгдсэн эмнэлгүүдэд эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, мэдээлэл сурталчилгааг хариуцан ажиллаж байгаа албан хаагчдын уялдаа холбоо хангалтгүйгээс ЭМД-ын хамрагдалт төлөвлөснөөс 2021 онд 38 хувь, 2022 онд 67 хувьтай гарчээ. 21

Б2.2. Аймгийн ЭМД-ын хэлтэс болон эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим программууд хоорондоо хөрвөх боломжгүй, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ байхгүй байна. 24

Б2.3 Даатгуулагчид орчин үеийн техник технологийг ашиглан социал мэдээллийн сувгаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг хүргэсэн бөгөөд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасны дагуу шийдвэрлэсэн байна. 26

БҮЛЭГ Б.3. ЭМДЕГ-ААС ТАВИХ ДОТООД АУДИТЫН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. 27

Б3.1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-аас хууль тогтоомж, журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн ЭМДХ-ийг 2021 онд 75 хувь, 2022 онд 50.8 хувиар үнэлжээ. 27

Б3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд орон тооны дутагдалтайгаас холбогдох стандарт, журмын дагуу хяналт тавьж чадахгүй байна. 28

Б3.3 Эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад хяналт тавьж байгаа хэдий ч тусламж үйлчилгээний чанарт тавих хяналт хангалтгүй байна. 29

Б3.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс ЭМЯ-наас 2022 оны жилийн эцэст үнэ төлбөргүй нийлүүлсэн 264.0 сая төгрөгийн хөрөнгийн эмийн хугацаа дуусаж, хөрөнгийн үр өгөөж гараагүй байна. 30

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 33

ДҮГНЭЛТ 34

ЗӨВЛӨМЖ 35

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ 37



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ББН	Бүрэн бус нөхөрлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОХБ	Оношны хамаарлын бүлэг
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭМТ	Тосгоны эрүүл мэндийн төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЭМДС-ын 2021, 2022 оны орлогын төлөвлөгөө	5
Хүснэгт 2	ЭМДС-ийн 2021, 2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	5
Хүснэгт 3	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага	6-7
Хүснэгт 4	ЭМДС-аас нэхэмжилсэн, олгосон санхүүжилт	7
Хүснэгт 5	Сонгон шалгаруулалтад оролцсон байгууллагын мэдээлэл	12
Хүснэгт 6	Даатгалын гэрээнд тусгаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл	13
Хүснэгт 7	Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт, хүний тоо	15
Хүснэгт 8	Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлын тооцоолол	16
Хүснэгт 9	ЭМД-ийн хамрагдалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (хүний тоогоор)	21
Хүснэгт 10	Ковид цар тахлын эсрэг тусламж үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо	22
Хүснэгт 11	ЭМБ-ын ашиглаж буй программ хангамж	25
Хүснэгт 12	Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн судалгаа	27
Хүснэгт 13	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчлийн нэгтгэл	30-31
Хүснэгт 14	Эм боох материалд хугацаа нь дуусах эмийн үлдэгдлийн судалгаа	31-32



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалаар баталсан Төрийн аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс болон холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын хамарсан хүрээ

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;

Аудитад Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар, Баянхонгор аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2021-2022 оны ЭМД-ийн санхүүжилт, тайлан, мэдээ, холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.



**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд**

- Төрийн аудитын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолууд
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020-2023 оны тушаалууд;
- Бусад холбогдох журам, аргачлал, стандартууд

**Аудитын
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Батчимэг нар хамтран гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг 2023.03.16-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2023.03.27-ны өдрөөс 2023.05.10-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2023.05.11-ээс эхлэн гүйцэтгэж, тайланг ТАГ-ын дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2023.05.19-ний өдөр Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, аймгийн ЭМГ, ЭМДХ, Нэгдсэн эмнэлэгт хүргүүлэв.

**Хүндрэл
бэрхшээл**

- Баянхонгор аймгийн ЭМДХ баталсан орон тоогоор ажиллаагүйгээс мэргэжилтнүүдийн ажлын ачаалал их, Архивын тухай хуулийн дагуу 2022 оны санхүүгийн баримт материалыг бэлтгээгээгүйгээс баримт материал үдэх, программаас мэдээллийг хөрвүүлэхэд цаг хугацаа их шаардсан;
- Тухайн аудитад нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, мэргэшил шаардагдаж байсан;
- Аудитын баг аудитыг гүйцэтгэх хугацаанд бусад аудит давхацсан, ахлах аудиторт ар гэрийн гачигдал гарсан зэргээс шалтгаалан аудитын гүйцэтгэх хугацаа богино байсан.



БҮЛЭГ А. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байна уу гэсэн 2 дахь түвшний асуудал нь орон нутагт хамааралгүй болно (аудитын загварын матрицаар ирүүлсэн чиглэл).

БҮЛЭГ Б.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ТАСАРСАН, САНХҮҮЖИЛТИЙГ ХЯНАЖ, ХАСАГДЛЫН ДҮНГ ЭХ ОЛОНЛОГТ НОГДУУЛАН ХАСЧ БАЙГААГААС ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД САНХҮҮГИЙН АЛДАГДАЛД ОРОХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

Б1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2022 онд үндэслэлгүй төлөвлөсөн, эрүүл мэндийн даатгалыг иргэдэд сурталчлах ажил хангалтгүйгээс орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1¹-д заасны дагуу ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулсан байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төсвийн хуваарийг ЭМДҮЗ-ийн 2021.01.22-ны өдрийн “2021 оны төсвийн хуваарь батлах тухай” 01 дүгээр тогтоолоор 2021 онд 4,378.7 сая, ЭМДҮЗ-ийн 2021.12.21-ний өдрийн “2022 оны төсвийн хуваарь батлах тухай” 08 дугаар тогтоолоор 2022 онд 8,308.3 сая төгрөгөөр баталсан байна.

Дээрх ЭМДҮЗ-ийн тогтоолуудыг үндэслэн ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/11, 2022 оны А/14 дүгээр тушаалаар 2021, 2022 оны аймаг, нийслэлийн эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт 1. ЭМДС-ын 2021, 2022 оны орлогын төлөвлөгөө (сая төг)

Он	Шийдвэр	ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө	Үүнээс		
			Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагсдын шимтгэл	Бусад орлого
2021	ЭМДҮЗ-ийн 2021.01.22-ны өдрийн 01 дүгээр тогтоол	4,378.7	3,520.3	854.9	3.5
2022	ЭМДҮЗ-ийн 2021.12.21-ний өдрийн 08 дугаар тогтоол	8,308.3	7,384.6	923.7	-

Эх сурвалж: ЭМДҮЗ-ийн тогтоолууд

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр дамжуулан эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж, сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг Төсөв программ руу татан, сангийн хуваарилалтыг хийдэг бөгөөд ЭМДС-ийн орлогын биелэлт 2021 онд 4,270.4 (97.5 хувь) сая, 2022 онд 5,054.4 сая (60.8 хувь) төгрөгийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. ЭМДС-ийн 2021, 2022 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төг)

№	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт /хувь /	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт /хувь /
1	Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	3,520.3	3,709.2	105.3	7,384.6	4,320.4	58.5
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагсдын шимтгэл	854.9	560.9	65.6	923.7	732.1	79.3
3	Бусад орлого	3.5	0.1	9.2	-	1.7	-
	Акт						
	Алданги		0.06			0.09	
	Харилцах дансны хүү		0.1				
Орлогын дүн		4,378.7	4,270.4	97.5	8,308.3	5,054.4	60.8

¹ Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;



Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад ЭМДС-ийн 2022 оны орлогыг төлөвлөхдөө 2021 оны орлогын гүйцэтгэлд үндэслэн тооцоогүй, өмнөх оны төлөвлөлтөөс хэт өндөр буюу 89 хувиар өндөр төлөвлөсөн, 2022 онд ажил олгогч даатгуулагчийн төлөх шимтгэлийг 51.0 хувиар нэмж баталсан зэргээс үзэхэд 2022 оны ЭМДС-ийн орлогын төлөвлөлт үндэслэлгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7²-д заасан иргэдийн даатгалын төлбөрийг төр хариуцаж байгаа ба орон нутгийн хэмжээнд шалгах боломжгүй, ХХҮЕГ-аас ЭМДЕГ-т мэдээллийг хүргүүлж байгаа гэсэн тайлбарыг хэлтсийн даргаар ажиллаж байсан албан хаагч өгч байгаа, тус хүргүүлсэн судалгаа нь ХХҮЕГ-ын 2017 онд хийгдсэн байгаа тул судалгааны үнэн зөв байдалд хяналт хийх, судалгааг шинэчлэх шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгийг ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор 9,504.2 сая, 2022 оны шилжүүлгийг ЭМДҮЗ-ийн 2021 оны 08 дугаар тогтоолоор 12,167.4 сая төгрөгөөр анх баталсан ба ЭМДҮЗ-ийн 2022.07.04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 4,240.1 сая төгрөгөөр бууруулан 7,927.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд 357,871 хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 25,709.8 сая, 2022 онд 295,984 хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 30,821.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

(сая төг)

№	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төрөл	2021 он		2022 он	
		Хүний тоо	Олгосон санхүүжилт	Хүний тоо	Олгосон санхүүжилт
1	Хэвтэн эмчлүүлэх	9,308	5,047.7	13,171	9,457.7
2	Нэг иргэнээр тооцох санхүүжилт	-	-	87,636	9,100.4
3	Амбулатори	51,965	962.8	79,881	2,070.5
4	Өдрийн эмчилгээ	943	180.2	7,269	648.0
5	Оношилгоо, шинжилгээ	35,405	737.4	8,350	121.7
6	Уламжлалт эмчилгээ	808	311.8	1,813	558.1
7	Хөнгөвчлөх	38	15.2	27	23.5
8	Рашаан сувилал	3,059	849.0	5,528	1,371.6
9	Эмийн үнийн хөнгөлөлт	54,384	1,594.7	59,206	1,660.4
10	Элэгний В, С вирусийн эмийн хөнгөлөлт	508	38.5	-	-
11	Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ	189	8.1	607	36.9
12	Хорт хаврын хими эмчилгээ	97	95.8	-	-
13	Элэгний В, С вирусийн илрүүлэг /баталгаажуулах/	418	1.7	-	-
14	Урьдчилан сэргийлэх	5,814	59.5	5	0.1
15	Гемодиализ	748	110.1	-	-
16	Өрхийн эмнэлэг	17,951	575.5	-	-
17	Ковидын-18 вакцин	142,488	712.4	1,470	48.0
18	Ковидын-19 өрх	7,193	1,063.1	2,703	428.3
19	Ковидын-19 хэвтэн	9,640	12,485.9	1,470	1,920.2
20	Төлбөрийг нь төр хариуцах эмийн санхүүжилт	-	-	135	7.5
21	Яаралтай тусламж	3,203	371.0	6,291	1,408.4
22	Түргэн тусламж	4,354	211.8	5,782	1,560.4

² нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; БНА-2023/19-3-ШТА-ГА



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө

23	Сэргээн засах үйлчилгээ	-	-	2,355	146.0
24	Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ	-	-	1,899	109.3
25	Ковид-19 сорьц авах /5000/	-	-	367	1.8
26	Ковид-19 сорьц шинжлэх /50000/	9,358	277.6	1,039	52.0
27	Эрт илрүүлэг	-	-	851	91.0
	ДҮН	357,871	25,709.8	295,984	30,821.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн жилийн эцсийн тайлан

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалыг арилжааны банкаар болон цахимаар төлсөн тохиолдолд 72 цагийн дараа төлөлт бүртгэгдэн, тухайн харьяаллын НДХ-т орлого бүртгэгдэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаа бол ebarimt.mn, ebarimt app-аар ЭМД төлсөн тохиолдолд 30 минутын дараа төлөлт бүртгэгдэн, орлого ЭМДЕГ-т бүртгэгдэж байна. Иймд цаашид иргэн ЭМД-ийг ямар хэлбэрээр төлснөөс үл шалтгаалан иргэний оршин суугаа харьяаллын дагуу орлогыг бүртгэдэг байх, ЭМД төлсөн дарууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлэх саналыг ЭМДЕГ-т ҮАГ-аар дамжуулан уламжилж байна.

Б1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянасан боловч нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр сар бүр тайлан гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээгүй, санхүүжилтийг журамд заасан хугацаанаас хоцроож олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМБ-ууд 2021 онд 28,262.0 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 2,552.2 сая төгрөг хасагдаж 25,709.8 сая, 2022 онд 34,584.2 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 3,762.3 сая төгрөг хасагдаж 30,821.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 4. ЭМДС-аас нэхэмжилсэн, олгосон санхүүжилт

(сая төг)

№	Эрүүл мэндийн байгууллага	2021 он			2022 он		
		Нэхэмжилсэн	Хасагдсан	Олгохоор тооцсон	Нэхэмжилсэн	Хасагдсан	Олгохоор тооцсон
1	Төрийн өмчийн ЭМБ	15,170.5	1,593.5	13,577.0	13,273.9	2,372.8	10,901.0
2	СЭМТ	7,196.9	636.1	6,560.8	13,134.6	450.0	12,684.6
3	ТЭМТ	153.3	20.5	132.9	406.0	1.2	404.8
4	ӨЭМТ	1,571.1	122.7	1,448.4	2,036.0	104.1	1,931.9
5	Хувийн хэвшлийн ЭМБ	1,613.5	105.0	1,508.5	1,981.6	114.1	1,867.6
6	Рашаан сувилал	912.1	63.1	849.0	2,048.6	677.0	1,371.6
7	Эмийн сан	1,644.6	11.4	1,633.2	1,703.5	43.1	1,660.4
	ДҮН	28,262.0	2,552.2	25,709.8	34,584.2	3,762.3	30,821.9

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны тайлан

Баянхонгор аймгийн ЭМДХ-ээс холбогдох хууль, тогтоомжийн дагуу даатгалын гэрээ байгуулсан газруудаас ирүүлсэн санхүүжилтийг хянаж, санхүүжилтийг олгохдоо хугацаа хоцроосон, нэхэмжлэлийн хяналтаар хассан шалтгаан, тайлбарыг эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргүүлээгүй нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1.2.3³-т заасныг зөрчсөн байна.

- Аудитын хугацаанд аймгийн Нэгдсэн эмнэлэг, 5 хувийн хэвшлийн эмнэлэг, 2 эмийн сан, 1 СЭМТ-өөс хасагдлын шалтгаан тайлбар ирдэг эсэхийг тодруулахад 1-2 удаа бичгээр

³ Чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хяналтын тайланг гаргах, дүн шинжилгээ хийх, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдлын мэдээллийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх хуудасны загвар"-ын дагуу дэлгэрэнгүй тайланг гаргаж сар бүр илгээх, эргэх холбоо тогтоох, иргэн, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах;



ирсэн боловч ямар шалтгаанаар хассан нь тодорхойгүй, ерөнхий шалгуур, эмнэл зүйн шалгуур хангаагүй гэсэн тайлбар ирсэн.

- Аудитын хугацаанд буюу 2023.05.09-ний өдөр Баянхонгор аймгийн 19 сумын ЭМТ, 1 тосгоны ЭМТ, 4 ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогчидтой Эрүүл мэнд мэндийн даатгалын тогтолцооны талаарх давуу болон сул тал, тулгамдаж буй асуудлын талаар ZOOM уулзалт хийхэд ямар шалтгаанаар хасагдсан нь тодорхойгүй байдаг гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтнууд өгсөн.

ЭМДС-аас санхүүжилтийг цаг хугацаанд нь олгох, мэргэжилтний нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан санхүүжилтийн шалтгаан тайлбарыг тухай бүр эрүүл мэндийн байгууллагад хүргүүлснээр дараагийн сард гарах алдаа, эрсдэлээс хамгаалах, зөрчлийн тоо буурч, санхүүжилтийг бүрэн авах бололцоог олгох тул аймгийн ЭМДХ-т аудитаар зөвлөмж хүргүүлэв.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөр хяналтын журам”-ын 4.1.1.5-д “Чанар, төлбөрийн хяналтыг хийж нэхэмжлэлийг хянахдаа нэхэмжлэлийн түүврийн хэмжээг тусламж, үйлчилгээний төрөл тус бүрээр тогтоож, түүврийн тохиолдлуудаас шалгуур хангаагүй хасагдлын хувийг тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хугацаанд хамаарах нийт нэхэмжлэлийн эх олонлогт нь ноогдуулах буюу нийт нэхэмжлэлийн мөнгөн дүнгээс хасаж тооцох” гэж заасны дагуу санхүүжилтийг хасаж олгож байгаагаас ЭМБ-аас үзүүлсэн бусад зөрчилгүй тохиолдлыг хасаж байгаа нь санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байх эрсдэл үүсэж байгааг төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн холбогдох албан тушаалтнууд асуудал дагуулж байгааг хэлж байсан Иймд цаашид эх олонлогт ногдуулан хасалт хийж байгаа асуудлыг салбарын хэмжээнд дахин авч хэлэлцэх саналыг ЭМДЕГ-т хүргүүлэв.

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2022.06.09-ний өдөр “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн хасагдал бууруулах, өвчний түүх бичилтийг сайжруулах” ажлын төлөвлөгөө боловсруулан 12 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч эцэслэн дүгнэж, ажлын тайлан гаргаагүй байна. Харин удирдлагын шуурхай хурал, эмч нарын хуралд тусламж үйлчилгээний гүйцэтгэл, хасагдал, санхүүжилт, цаашид анхаарах асуудлын талаар танилцуулдаг, 2022 оны 10 дугаар сард Улсын 1 дүгээр төв эмнэлгээс үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, эмч, даатгалын эмч, IT инженер нар ирж ажлын байрны сургалт хийсэн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн албан хаагчид Улсын 1 дүгээр төв эмнэлэгт санхүүжилтийн тогтолцооны талаар туршлага судалсан, ЭМЯ-аас 2022 оны 9 дүгээр сард, аймгийн ЭМДХ-ээс 12 дугаар сард эмнэл зүйн шалгуур үзүүлэлтийн талаар эмч нарт сургалтыг хийсэн байна.

2022.06.11-2022.07.31-ний өдрүүдэд “Баян-Энэрэл” ББН эмнэлгээс 5 даатгуулагчид үзүүлсэн 1.4 сая, “Шинэ хүн” эмнэлгээс 9 даатгуулагчид үзүүлсэн 2.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч чадаагүй асуудлыг тодруулж өгөхийг хүссэн ба, аудитын багаас “Шинэ хүн” эмнэлгийн 003 ОХБ-ээр хасагдсан 1 даатгуулагчийн санхүүжилтийг хасах нь зүйтэй гэж үзэж, бусад даатгуулагчийн хэвтэн эмчлүүлсэн ОХБ нь даатгалын гэрээнд тусгасан байгаа тул тус асуудлыг аймгийн ЭМДХ-ээр тодруулан үзэж, шийдвэрлэх асуудлыг ЭМДЕГ-т хүргүүлэв.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар сүрьеэ, хорт хавдрын гурав, дөрөвдүгээр үе шат (хөнгөвчлөх эмчилгээ), сэтгэцийн эмгэг, чихрийн шижин, чихрийн бус шижин өвчлөлийн үед “Төлбөрийг төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”-ыг баталсан, тус тогтоолын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг 2021 онд 4.4 сая, 2022 онд 9.2 сая төгрөгийн төрөөс хариуцах эмийг олгосон байна. Аудитаар олгосон эмийг өвчний оношоор гарган дүн шинжилгээ хийхэд олгосон эмийн 90.8-91.3 хувийг инсулинээс үл хамаарах чихрийн шижин өвчний эмийн



үнэнд олгосон бол хорт хавдрын өвчлөлд 8.6-5.3 хувийг олгосон байгаад аймгийн ЭМГ хяналт тавьж ажиллах, цаашид тогтоолд заасан өвчний үед олгох эмийг иргэдэд жигд хүртээмжтэй олгох шаардлагатай байна.

Төлбөрийг төрөөс хариуцах эмийг олгохдоо эмч өвчтөний карт дээр бүрэн бичээгүй, үнэгүй эм авсан хүний дийлэнх нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажилладаг албан хаагч, албан хаагчдын хамаарал бүхий этгээд байгаа тул цаашид дээрх тогтоолыг иргэдэд сурталчлах, ялангуяа хорт хавдрын өвчинтэй иргэдэд тусламж үйлчилгээг түлхүү хүргэхэд анхаарч ажиллах, цаашид тогтоолд заасан өвчний үед олгох эмийг иргэдэд жигд хүртээмжтэй олгох зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлэв.

Аудитын баг аймгийн Нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, сумдын ЭМТ-ийн 55 эмч, хэвтэн эмчлүүлж байгаа 153 даатгуулагчаас санал асуулга авч, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэнтэй хамтран 1,096 иргэнээс цаасаар болон цахимаар санал асуулга авч ажилласан.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн иргэн өөрөөс хэрэглэсэн эм тарианы үнэнд 2021 онд 17 иргэнд 6.5 сая, 2022 онд 1 иргэнд 0.6 сая төгрөгийг олгожээ. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 153 иргэнээс санал асуулга авахад “Стори дээр бичүүлж гаднаас худалдан авсан эм, тарианы мөнгийг буцаан авдаг болохыг та мэдэх үү?” гэсэн асуултад 81.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан, санал асуулгад оролцсон иргэний 13.7 хувь нь хэвтэн эмчлүүлж байгаа хугацаандаа гаднаас эм тариа авсан гэж хариулсан байгаагаас үзэхэд цаашид иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг олгох сургалт, сурталчилгааг явуулах, гаднаас эм тариа авсан нөхцөлд буцаан олгож байхыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагад зөвлөв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн ЭМДС-аас нэхэмжилсэн зардлын дүнд ЭМД-ын шимтгэл бүрэн төлсөн, даатгалын системд олгох төлөвтэй боловч системийн алдаанаас олгох мөнгөн дүн нь 0 дүнтэй болсон 2021 оны 388 даатгуулагчийн 113.7 сая, 2022 оны 61 даатгуулагчийн 7.5 сая төгрөгийн санхүүжилтийг дахин хянах саналыг аудитын гүйцэтгэлийн үе шатны төгсгөлд даатгуулагчийн нэрсийг жагсаалтаар ирүүлсэн. Энэ талаар аймгийн ЭМДХ-ээс тодруулахад тайлбар ирүүлээгүй, аудитын хугацаанд тодруулан шалгах цаг хугацаа байгаагүй тул гомдлын дагуу дахин хяналт шалгалтыг хийж, шийдвэрлэхийг ЭМДЕГ-т хүргүүлэв.

Б1.3. Баянхонгор аймагт эрүүл мэндийн салбарт ажиллах хүний нөөц дутагдалтай, аймгийн ЭМДХ баталсан орон тоогоор ажиллахгүйгээс цаашид санхүүжилтийг хянахад эрсдэл үүсэхээр байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга нь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргатай 2020.10.01-ний өдрийн 09 дүгээр гэрээгээр аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн 35 кв.м талбайтай өрөөг түрээсийн төлбөр төлөхгүйгээр албан хэрэгцээний зориулалтаар ашиглах гэрээг байгуулсан байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/29, 2022 оны А/08 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагааны зардлыг 2021 онд 3.1 сая, 2022 онд 7.4 сая төгрөгөөр төлөвлөж, хэлтэс нь арилжааны банканд харилцах данс байхгүйгээс үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлуудын нэхэмжлэлийг харилцагч байгууллагаас хүлээн авч ЭМДЕГ-т хүргүүлэн төлбөр тооцоог гүйцэтгэж иржээ.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн дарга 1 /ТЗ-7/, чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 4 /ТЗ-6/ нийт 5 орон тоогоор баталсан боловч ЭМДЕГ-ын даргын 2023.01.13-ны өдрийн Б/19 дүгээр тушаалаар хэлтсийн даргыг үүрэгт ажлаас чөлөөлснөөс хойш тус хэлтэс чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн 2 оронтойгоор үйл ажиллагаа явуулж иржээ.



Төрийн албаны салбар зөвлөлийн 2021.03.17-ны өдрийн 99 дүгээр тогтоолын 19 дүгээр хавсралтаар “Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн”-ний албан тушаалын тодорхойлолтод Анагаах ухаан, бизнес ба удирдахуй, эрх зүй, эдийн засаг, статистик зэрэг мэргэжлийн хүн байхаар заасан бөгөөд хүний их эмч мэргэжилтэй 1 мэргэжилтэн 2023 оны 5 дугаар сард ажлаас гарснаар тус хэлтэст одоогоор даргын үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа эдийн засагч мэргэжил эзэмшсэн 1 мэргэжилтэн ажиллаж байгаа нь ЭМБ-аас ирсэн нэхэмжлэлд эмнэл зүйн хяналтыг хэрэгжүүлэхэд цаашид эрсдэл үүсэх магадлалтай байна.

Иймд “Чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн”-ний албан тушаалын тодорхойлолтод эрүүл мэндийн салбар, эмнэл зүйн боловсролтой хяналт тавих мэргэшсэн мэргэжилтнийг түлхүү ажиллуулахаар өөрчлөлт оруулах саналыг ЭМЯ-д хүргүүлж байна.

ЭМДЕГ-аас албан хаагчдыг томилдог бөгөөд Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн даргын 2021.01.21-ний өдрийн 04 тоот албан бичгээр ЭМДЕГ-т хүний их эмч Г.Цэдэнсодномыг ажилд авах хүсэлтийг хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй, тус хэлтэст дутагдалтай байгаа орон тоог нөхөх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд цаашид аймгийн ЭМДХ-ийг бүрэн орон тоогоор ажиллуулах, боловсон хүчний асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх саналыг ЭМДЕГ-т хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ЭМДХ-т 3, аймгийн ЭМГ-т 6 орон тооны дутагдал байгаа нь дараах шалтгаантай гэсэн тайлбарыг холбогдох байгууллагууд өгч байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний эрүүл мэнд, төрийн захиргааны албан тушаалын цалин, урамшуулал зөрүүтэй (төрийн захиргааны албан хаагчийн цалин бага);
- Төрийн захиргааны албан тушаалд илүү цагаар ажиллах, илүү цагийн хөлс тооцох боломжгүй, ур чадварын нэмэгдэл авдаггүй;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн цалин бага тул төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгөхөөс зайлсхийдэг;
- Төрийн захиргаанд ажиллаж байгаа их эмчийн цалин хөлс, аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа их эмчийн цалингаас бага, ажлын ачаалал их;
- Эмч, мэргэжилтнүүд мэргэжлээ дээшлүүлэн мэргэжлээрээ ажиллах сонирхолтой байна.

Иймд цаашид аймгийн ЭМДХ, Эрүүл мэндийн газар зэрэг төрийн захиргааны алба хашиж байгаа хүний эмч нарын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэж байх асуудлыг ЭМЯ-аас анхаарах нь зүйтэй байна.

Аймгийн ЭМГ-аас авсан судалгаагаар 2023 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн Нэгдсэн эмнэлгээс бусад сум, өрхийн ЭМТ-д нийт 50 орон тоо дутагдалтайгаас 9 их эмч, 13 багийн эмч, 16 сувилагч дутагдалтай байгаагаас харахад эрүүл мэндийн салбарт ажиллах боловсон хүчнийг сургах, бодлогоор дэмжих асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс авсан судалгаагаар ерөнхий мэргэжлийн их эмч, хоол зүйчийн орон тоонд сул ажлын байрны зар явуулсан ч ирдэггүй, нийт хүүхэд асрах чөлөөтэй 12 сувилагч байгаагаас сувилагчийн орон тоо дутагдалтай, мөн аудитын явцад тасаг бүрээр нэг эмчид ногдох хэвтэн эмчлүүлэгч, нэг сувилагчид ногдох хэвтэн эмчлүүлэгчийн тоог гаргахад тасаг тус бүрээр 2 онд харилцан адилгүй байгаа тул цаашид дутагдалтай байгаа боловсон хүчин, тасгийн их эмч, сувилагч нарын ачааллыг тэнцвэртэй байлгах асуудалд дүн шинжилгээ хийж, менежментийг сайжруулах нь зүйтэй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн албан хаагчдын үндсэн цалин Засгийн газрын 472, 107 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн ба нэг иргэнд ногдох гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2022.08.12-ны өдрийн А/28 дугаар тушаалаар албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн ба, 2023.01.13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 2023.01.01-2023.03.31-ний өдрийг хүртэлх хугацаанд байгууллагын эмгэг судлаач их эмчийн үндсэн цалинг 40 хувиар, бусад ажилтнуудын үндсэн



цалинг 20 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарган, 2023.04.01-ний өдрөөс эхлэн Засгийн газрын 107 дугаар тогтоолоор олгосон байна. Энэ нь 2022 онд ковидын санхүүжилт өндөр байсан, 2023 онд гүйцэтгэлээр олгож байгаа санхүүжилтийг эх олонлогт тооцож олгосноор хасагдал ихтэй гэсэн тайлбарыг ирүүлж байгаа болно. Иймд цаашид аймгийн Нэгдсэн эмнэлэг санхүүжилтийн хасагдлын шалтгааныг тухай бүр аймгийн ЭМДХ-ээс тодруулж, оношийг буруу бичсэн, анхан шатны баримтыг дутуу ирүүлсэн зэргээс хасагдсан санхүүжилттэй уялдуулан үр дүнтэй нь тооцон ажиллах нь зүйтэй байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг 2018-2022 онд нийт 95 эмч, мэргэжилтнүүдийг үндсэн болон төрөлжсөн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр суралцуулснаас 2023.05.03-ны байдлаар 75 албан хаагч ажиллаж, 8 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа, 11 албан хаагч сурч байна.

Аудитын илрүүлэлт

- *Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүрс оношилгооны их эмч 6 сарын хугацаанд дурангийн эмчээр мэргэшин, суралцах хугацаанд үндсэн цалингаар цалинжуулсан байхад тус их эмч өөрийн хүсэлтээр 2022.12.22-ны өдөр ажлаасаа гарсан байна. (ирүүлсэн судалгаанд 2022.04.10-ны өдөр гэрээ байгуулсан, 2027.04.10-ны хүртэлх хугацаанд ажиллахаар гэрээнд заасан гэсэн боловч гэрээг аудитын байгууллагад ирүүлээгүй, их эмч өөрийн зардлаар суралцсан гэсэн тайлбарыг аймгийн Нэгдсэн эмнэлгээс өгсөн)*

Иймд цаашид гэрээ байгуулан, үндсэн цалинг олгож үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлээр мэргэжил дээшлүүлсэн албан хаагчийг гэрээнд заасан хугацаанд нь тогтвортой ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хохирлыг нөхөн төлүүлж байх зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс гаргуулсан 2021-2022 онд баталсан орон тоог гүйцэтгэлтэй нь харьцуулсан судалгаа, аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдаас эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаа судалгааг гаргуулан авахад нүүр амны их эмч 6 орон тоо байхаас 3 эмч хүүхдээ асрах чөлөөтэй байгаа ба үүний 2 эмч нь шүдний хувийн эмнэлэгт үндсэн орон тоогоор ажиллаж байгаа гэсэн судалгаа ирүүлсэн байна.

Аудитын явцад аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэгийн цаг тараалтын судалгааг 2023.04.27-ны өдөр авахад шүдний 1 эмч 2023.05.10-ны өдөр хүртэл хугацаанд чөлөө авсан, шүдний оочир нэг шүдний эмч дээр 2023.05.02, нөгөө шүдний эмч дээр 2023.05.05-ны өдөр хүртэл буюу ажлын 3-6 хоногийн дараа иргэн шүдний эмчид үзүүлэхээр байгаа нь иргэд төрийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүйгээс хувийн хэвшлийн шүдний эмнэлгийг сонгон эмчлүүлэх гол шалтгаан болж, эрүүл мэндийн даатгалыг төлсний үр ашгийг хүртэж чадахгүйд хүрч байна.

Иймд цаашид хүүхэд асрах чөлөөтэй байгаа шүдний эмчийн асуудлыг хууль эрх зүйд нийцүүлэн шийдвэрлэж, баталсан орон тооны эмч нарыг ажиллуулах нь зүйтэй байна.

Аудитын илрүүлэлт

- *Эрүүл мэндийн байгууллагууд ЭМДҮЗ-ийн 2022.01.28-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хэвсрэлтээр батлагдсан "ЭМДС-аас зардлын төлбөрийг нь төр хариуцах тусламж үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тохиолдлыг ЭМДС-аас санхүүжүүлэх журам"-ын Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эмийн эмчилгээтэй холбоотой холбогдох бусад зохицуулалтын 8-д "Жирэмсэн болон 0-18 насны хүүхдийг Ковид-19-ийн U07 оношны хөнгөн тохиолдлоор хэвтүүлэн эмчилсэн тохиолдолд хэвтүүлэн эмчлэх 234361 код бүхий "Ангилагдаагүй бусад" ОХБ-ээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. Бусад иргэн, даатгуулагч Ковид-19-ийн U07 оношны хөнгөн тохиолдлоор хэвтүүлэн эмчлүүлсэн тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй бөгөөд төлбөрийг иргэн, даатгуулагч өөрөө хариуцан төлж, тус тусламж, үйлчилгээг авна" гэсэн заалтыг зөрчин 2022.02.02-2022.03.01-ний өдрийн хооронд U07 оношны хөнгөн тохиолдлоор хэвтүүлэн эмчилсэн 400 иргэнийг U07*



ОХБ-ээр буюу 0.9 сая, нийт 392.0 сая төгрөгийг ЭМДС-аас нэхэмжилж, оношны хамаарлын бүлгийн зөрүүгээс сангаас 300.0 сая төгрөгийг илүү олгосон;

- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн диализын тусламж үйлчилгээний нэхэмжлэлийн жагсаалтыг ЭМДХ-ын цахим систем /<https://health.gov.mn/>-тэй түүврийн аргаар тулган шалгахад диализын тусламж үйлчилгээгээр 2021 онд 4 тохиолдлын 0.4 сая, 2022 онд 2 тохиолдлын 0.2 сая, нийт 0.6 сая төгрөгийг 2 өөр кабинетаас Z49.1 гэсэн оношоор 1 өдөрт давхардуулан нэхэмжилсэн байхад төлбөрийг олгосон;
- Баянбулаг сумын ЭМТ-ын 2022 оны U07 ОХБ-ээр (Ковид) хэвтэн эмчлүүлсэн иргэдийн мэдээллийг бусад шинжилгээ, өрхийн эмчилгээний нэхэмжлэхтэй тулгалт хийхэд 2022 оны 1 дүгээр сард 8 иргэний 0.1 сая төгрөгийн оношилгоо, 4 иргэний 0.3 сая төгрөгийн өрхийн эмчилгээний нэхэмжлэхийг ЭМДС-аас давхардуулан нэхэмжилж авсан зөрчил илэрлээ.

Иймд цаашид оношны хамаарлын бүлгийг зөв бүртгэж, нэхэмжилж байх зөвлөмжийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэв.

Б1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэмэлт сонгон шалгаруулалтад хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүрээнд иргэдэд үзүүлэх боломжтой оношны хамаарлын бүлгийг нэмээгүйгээс иргэдэд олгох боломжтой эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж чадахгүй байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 1.4⁴-т заасны дагуу Баянхонгор аймгийн 19 СЭМТ, 4 ӨЭМТ, 1 ТЭМТ-тэй ЭМДЕГ шууд гэрээ байгуулсан байна.

ЭМДҮЗ-ийн 2018 оны 09, 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 3.1⁵-д заасны дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд сонгон шалгаруулалтад дараах ЭМБ-ууд орсон байна.

Хүснэгт 5. Сонгон шалгаруулалтад оролцсон байгууллагын мэдээлэл

№	ЭМБ-ын нэр	ЭМБ-ын төрөл	Сонгон шалгаруулалтад орсон оношны бүлгийн тоо	Оношны бүлгийн тоо		Газар дээрх хяналт шалгалт	
				Тэнцсэн	Тэнцээгүй	Тэнцсэн	Тэнцээгүй
1	Нэгдсэн эмнэлэг	Улсын нэгдсэн эмнэлэг	502	481	14	6	1
2	Баян-Энэрэл	Хувийн эмнэлэг	35	25	10	-	-
3	Бургатай		8	4	4	-	-
4	Мандал баян булаг		42	19	21	-	2
5	Нарбад		32	17	12	-	3
6	Шинэ төв		45	29	16	-	-
7	Шинэ хүн		35	32	3	-	-
8	Ган зүү		14	14	0	-	-
9	Шаргалжуут	Рашаан сувилал	25	1	0	24	-
10	Баян-Ундарга зэндмэнэ		6	1	0	5	-
	Нийт		744	623	80	35	6

Эх сурвалж: ЭМБ-аас авсан судалгаа, ЭМДЕГ-тай байгуулсан даатгалын гэрээ

Сонгон шалгаруулалтад 1 төрийн өмчийн ЭМБ, 7 хувийн хэвшлийн ЭМБ, 2 рашаан сувилал нийт 703 ОХБ-аар оролцсоноос 632 ОХБ тэнцэж, 6 ОХБ газар дээрх хяналтаар тэнцэн, 65 ОХБ тэнцээгүй нь байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сонгон шалгаруулалтад тэнцээгүй шалтгаан нь орон тооны эмчгүйгээс гэрээт эмчээр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлсэн, зөвхөн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт зөвшөөрөх ОХБ-д санал өгсөн, газар дээр хяналтаар хоол зүйч эмч байхгүй, хувийн эмнэлгүүдийн тэнцээгүй шалтгаан нь мэргэжлийн боловсон хүчин болон тоног төхөөрөмжийн дутагдалтай байсантай холбоотой байна.

⁴ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан улсын төсвөөр санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг сонгон шалгаруулалтад хамруулахгүйгээр тэдгээр байгууллагатай шууд гэрээ байгуулж болно.

⁵ Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах, зохион байгуулах, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийн санал боловсруулах үндсэн нэгж нь Эрүүл мэндийн даатгалын өрөнхий газрын сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн асуудал хариуцсан нэгж байна.



Сонгон шалгаруулалтад тэнцсэн оношны бүлгийг төрлөөр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Даатгалын гэрээнд тусгасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл

Тусламж үйлчилгээний төрөл	Улсын нэгдсэн эмнэлэг	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага							Рашаан сувилал	
	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг	Баян-Энэрэл	Бургатай	Мандаг баян булаг	Нарбад	Шинэ төв	Шинэ хүн	Ган зүү	Шаргалжууг	Баян зэндмэнэ ундарга
Хэвтүүлэн эмчлэх	Эмийн эмчилгээ	198	25	1	18	17	2	8	14	
	Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими бай эмчилгээ	1								
Амбулатори	Мэс засал	197					17	11		
	Эрчимт эмчилгээ	1								
Уламжлалт	Амбулатори	14		3	3	3	1	6		
	Өндөр өртөгтэй ОШ	3								
Хөнгөвчлөх	Хэвтүүлэн	14							14	5
	Амбулатори	1								
Сэргээн засах	Өдрийн эмчилгээ	1								
	Хэвтүүлэн эмчлэх	1							11	1
Яаралтай тусламж	Амбулатори	1								
Түргэн тусламж	Өдрийн эмчилгээ	1								
Өдрийн эмчилгээ	Эмийн эмчилгээ	5								
	Мэс засал	5								
Бусад өдрийн эмчилгээ	Эмийн эмчилгээ	1					1	1		
	Мэс засал	42					8	6		
ДҮН	Бусад өдрийн эмчилгээ	1								
	ДҮН	487	25	4	21	20	29	32	14	25

Эх сурвалж: ЭМДЕГ-тай байгуулсан 2022 оны даатгалын гэрээ

Даатгалын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс Сэргээн засах тусламж үйлчилгээ, Нүдний мэс засал, Түлэнхийн мэс засал, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал хийх, БЗДХ-ын ПГУ шинжилгээ хийх үйлчилгээг иргэдэд шинээр үзүүлэх боломжтой байна.

Даатгалын гэрээг 2022 оны 9 дүгээр сард 3 жилээр байгуулсан, зохицуулалт хэрхэн хийх нь тодорхойгүй байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх хүний нөөц бүрэн хангагдсан, зарим тоног төхөөрөмжийг нэмэгдүүлснээр шинэ үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой байгаа ч ЭМДЕГ-ийн гэрээнд байхгүй, нэмэлт сонгон шалгаруулалтын шаардлагатай оношны бүлэгт багтаагүй байна.

Иймд ЭМДЕГ-аас нэмэлт сонгон шалгаруулалтын оношны хамаарлын бүлгийг хязгаарлахгүйгээр хөдөө, орон нутгаас иргэдэд үзүүлэх боломжтой эмчилгээ, үйлчилгээний саналын сонгон шалгаруулалтыг тухай бүрд нь шийдвэрлэж байх саналыг ЭМДЕГ-т хүргүүлэв.

Б1.5. ЭМДЕГ-тай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээг тухай бүр дүгнээгүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2021-2022 онд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай дараах эрүүл мэндийн байгууллагууд гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6. ЭМДЕГ-тай даатгалын гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын тоо

№	ЭМБ-ын төрөл	Даатгалын гэрээ байгуулсан ЭМБ-ын тоо	
		2021 он	2022 он
1	Төрийн өмчийн ЭМБ	1	1
2	Сумын ЭМТ	19	19
3	Тосгоны ЭМТ	1	1
4	Өрхийн ЭМТ	4	4
5	Хувийн хэвшлийн ЭМБ	7	7
6	Рашаан сувилал	2	2
7	Эмийн сан	42	41
	ДҮН	76	75

Эх сурвалж: Даатгалын гэрээнүүд



ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/175, ЭМДЕГ-ын даргын 2023 оны А/14 дүгээр тушаалын дагуу эмийн сангийн 2021, 2022 оны даатгалын гэрээг аймгийн ЭМДХ-ээс дүгнэсэн байна.

Үнэлгээнд 2021 онд “Увьдаст ундарга” эмийн сан төлөөлөл ирээгүй, 2022 онд “Маралжин” эмийн сан материал ирүүлээгүй, 3 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлсэн шийдвэр гарсан тул 2021 онд 41, 2022 онд 37 эмийн сангийн даатгалын гэрээг үнэлсэн байна.

Үнэлгээ	Эмийн сангийн тоо	
	2021 он	2022 он
90-100	24	21
80-89	17	14
80-аас бага	0	2
Дүн	41	37

Даатгуулагчид эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг дүгнэсэн тухай илтгэх хуудаст “эм худалдан авалттай холбоотой мэдээллийг харах зориулалт бүхий дэлгэцийг касс дээр байршуулаагүй” гэсэн сул тал бичсэн байгаа нь аудитын явцад зарим эмийн сангуудад дээрх зөрчил илэрсэн тул цаашид даатгалын гэрээний 2.4.12⁶-т заасныг мөрдөж ажиллах байгаад хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЭМДХ-т хүргүүлэв.

ЭМДЕГ-ын даргын 2022.01.11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн 19 сумын эрүүл мэндийн төв, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 1 тосгоны эрүүл мэндийн төвийн 2021 оны даатгалын гэрээг дүгнэх шийдвэр гаргасны дагуу аймгийн ЭМДХ-ээс чанар, төлбөрийн хяналтын 2 мэргэжилтэн гэрээ дүгнэх үйл ажиллагааг 2022.01.17- 2022.01.18-ны өдрүүдэд зохион байгуулжээ.

Дээрх эрүүл мэндийн байгууллагыг 15 шалгуур үзүүлэлтээр дүгнэснээс 1 сумын эрүүл мэндийн төв 90 хувь, 4 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төв 85 хувь, 14 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төв, 1 тосгоны эрүүл мэндийн төв 80 хувьтай үнэлэгдсэн байна.

ЭМДЕГ-ын даргын 2022.02.07-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн 1 төрийн өмчийн ЭМБ, 7 хувийн хэвшлийн ЭМБ, 2 рашаан сувиллын 2021 оны гэрээг дүгнэх шийдвэр гарсан боловч гэрээг дүгнээгүй, аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ, ӨЭМТ, рашаан сувилал, хувийн хэвшлийн эмнэлгийн 2022 оны гэрээг дүгнээгүй байгаа нь ЭМДЕГ-аас шалгуур үзүүлэлтийн шинэчлэл ирээгүйтэй холбоотой байна.

Даатгалын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж жил бүр дүгнээгүй нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁷, ЭМДЕГ болон ЭМБ-ийн хооронд байгуулсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний 1.5⁸-д заасныг зөрчсөн байгаа тул аудитаар зөвлөмж хүргүүлэв.

Б1.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор баталсан тусламж үйлчилгээний суурь өртгийн тариф, итгэлцүүрийг зах зээлийн үнэ ханштай уялдуулан шинэчлэхээр байна.

ЭМДС нь 2021 оны эхэнд ЭМБ-аас 0.9 сая төгрөгийн авлага, 0.1 сая төгрөгийн өглөгтэй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 357,871 иргэний тусламж үйлчилгээнд 25,709.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоос тус онд 18,992.9 сая төгрөгийг олгож, оны эцэст 29.8 сая төгрөгийн авлагатай, 6,745.8 сая төгрөгийн өглөгтэй байна.

⁶ хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг даатгуулагч, иргэдэд зориулан ил тод, харагдахуйц газар байршуулах ба даатгуулагчийг эмийн талаарх үнэн зөв мэдээллээр хангаж, олгосон эмийг хэрэглэх зааварчилгааг өгөхөөс гадна эмийн сонголт болон эм худалдан авалттай холбоотой мэдээллийг харах зориулалт бүхий дэлгэцийг кассан дээр байршуулах;

⁷ Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ.

⁸ Энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд жил бүр хийх дүгнэлтэд үндэслэн гэрээний баримт бичигт холбогдох өөрчлөлт хийнэ.



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө

Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж 2022 онд 295,984 иргэний тусламж үйлчилгээнд 30,821.9 сая төгрөг олгохоос, гүйцэтгэлээр сангаас 37,892.8 сая төгрөгийг олгож, оны эцэст 327.9 сая төгрөгийн авлагатай, 3.4 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Хүснэгт 7. Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт, хүний тоо

(сая төг)

№	Эрүүл мэндийн байгууллага	2021 он		2022 он	
		Хамрагдсан хүний тоо	Мөнгөн дүн	Хамрагдсан хүний тоо	Мөнгөн дүн
1	Төрийн өмчийн ЭМБ	125,714	13,577.0	106,217	10,901.0
2	Сумын ЭМТ	96,147	6,560.8	78,795	12,684.6
3	Тосгоны ЭМТ	2,236	132.9	1,828	404.8
4	Өрхийн ЭМТ	72,693	1,448.4	40,370	1,931.9
5	Хувийн хэвшлийн ЭМБ	3,130	1,508.5	4,040	1,867.6
6	Рашаан сувилал	3,059	849.0	5,528	1,371.6
7	Эмийн сан	54,892	1,633.2	59,206	1,660.4
	ДҮН	357,871	25,709.8	295,984.0	30,821.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн судалгаа

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо 2022 онд буурсан үзүүлэлттэй байгаа боловч олгосон санхүүжилт 5,112.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд сумын ЭМТ-д нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг олгосон, 2021 онд цар тахалтай холбоотой халдварт өвчний өвчлөл их байсан зэрэг нь голлох нөлөө үзүүлжээ.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Баянхонгор аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад дараах давуу талууд үүссэн байна. Үүнд:

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг

- Урологийн мэс засал, хавдрын бай эмчилгээ, компьютер томографи, сэтгэцийн тусламж, үйлчилгээ, давсагны дуран, дуплекс (тархины судасны хэт авиа оношилгоо) зэрэг үйлчилгээ шинээр нэмэгдсэн байна.

- Тус эмнэлэг нь 2022 онд өөрийн 434.8 сая төгрөгийн хөрөнгөөр хэвтүүлэн эмчлэх 3 тасаг, хоол үйлдвэрлэлийн хэсэгт их засварын ажил хийснээр ажилчдын ажиллах орчин сайжирч, үйлчлүүлэгч тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдсэн байна. Мөн 2023 онд Мэс заслын вакум хагалгааны блокт их засвар хийж байна.



- Ажилтан албан хаагчдын үндсэн цалинг байгууллагын удирдлагын зөвлөлийн 2022.12.08.12-ны өдрийн хурлаар хэлэлцэн 2022.12.31-ний өдөр хүртэл 20 хувиар нэмэгдүүлэн олгосон байна.

- Тасаг нэгжүүдээс тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгааг авч удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж эрэмбэлэн 6 багцад 201 нэр төрлийн 405.0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийн тендер зарлаж, нийлүүлснээр тоног төхөөрөмжийн хангамж, нэр төрөл нэмэгдсэн байна.

- Байгууллагын гадна тохижилтыг сайжруулах, ажилчдын авто зогсоол хийх, актлагдсан барилгын талбайг чөлөөлөх, цахилгааны 6000кв-ын өндөр хүчдэлийн под станцыг шинээр хийх зэрэг ажилд 110.3 сая төгрөгийг зарцуулсан байна.



Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв.

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих чиглэлээр 19 сумын ЭМТ, 4 өрхийн ЭМТ, 1 тосгоны эрүүл мэндийн 2022 онд 285 ажилтан албан хаагчид 229.5 сая төгрөгийн нэг удаагийн урамшуулалт цалин олгосон байна.
- Баянхонгор сумын 4 ӨЭМТ ажилтан албан хаагчдад сар бүр 40 хүртэл хувийн цалингийн урамшуулал олгодог болсон байна.

Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээ

ЭМДҮЗ-ийн 2022.04.05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”-ыг баталсны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 оны 5 дугаар сараас тус үйлчилгээг үзүүлж эхлэн, Дэмжих төвийг байгуулсан байна.

Аудитаар эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд зарцуулж байгаа зардлыг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эдийн засагчаар өртгөөр нь тооцон гаргуулан дүн шинжилгээ хийхэд ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор баталсан тарифаар 18-30, 31-45 насны 2 багцын үзлэг алдагдалтай гарч байна.

Хүснэгт 8. Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлын тооцоолол (төгрөгөөр)

№	Үзлэгийн төрөл	Насны ангилал			
		18-30	31-45	46-60	61-с дээш
1	Биохими /Холестерин, триглицерид, Алат,Асат, Билирубин шууд, амилаза, креатини, мочевины/	31,179	31,179	31,179	31,179
2	ХДХВ илрүүлэх тест	7,318	7,318		
3	Тэмбүү	7,864	7,864		
4	В вирус тест	4,203	4,203	4,203	4,203
5	С вирустест	4,333	4,333	4,333	4,333
6	Цээжний рентген	10,000	10,000	10,000	10,000
7	Эсийн шинжилгээ ПАП тест	6,200	6,200	6,200	
8	Цус, шээсний шинжилгээ	20,900	20,900	20,900	20,900
9	Зүрхний цахилгаан бичлэг	9,800	9,800	9,800	9,800
10	Өлөн үеийн глюкоз	-	3,000	3,000	3,000
11	Өтгөнд далд цус илрүүлэх			12,000	12,000
12	Ходоод, улаан хоолойн дуран		7,500	7,500	7,500
13	Хэвлийн ЭХО		5,000	5,000	5,000
14	Бамбай ЭХО		5,000	5,000	5,000
15	Хөхний ЭХО		5,000	5,000	5,000
16	ДОХ, БЗДХ	5,000	5,000	5,000	5,000
17	Сүрьеэ	5,000	5,000	5,000	5,000
18	Эмэгтэйчүүд	5,000	5,000	5,000	5,000
19	Дүгнэлт	5,000	5,000	5,000	5,000
	ДҮН	121,797	147,297	144,115	137,915
	ЭМДС-аас санхүүжих дүн /ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 тогтоол/	60,000	130,000	150,000	140,000
	Зөрүү	(61,797)	(17,297)	5,885	2,085

Эх сурвалж: ЭМДҮЗ-ийн тогтоол, Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эдийн засагчийн хийсэн тооцоолол

Иймд эмнэлгийн тусламж үйлчилгээний суурь өртгийг тарифыг дахин тооцох саналыг ЭМДЕГ-т УАГ-аар дамжуулан хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 2022.05.01-2023.04.30-ны хооронд нийт 6,183 даатгуулагч хамрагдсанаас ӨЭМТ-ийг харьцуулахад Оточмандал ӨЭМТ 1320 даатгуулагч хамруулсан нь хамгийн их, Энхбүрд ӨЭМТ 407 даатгуулагч хамруулсан нь хамгийн бага дүнтэй байна.



Харин сумдыг харьцуулбал Баацагаан 410 даатгуулагч хамруулсан нь хамгийн их, Бөмбөгөр 70, Шинэжинст 65 даатгуулагч хамруулсан нь хамгийн бага дүнтэй байна.

Иймд цаашид ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЭМГ-т хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн мэдээллээр эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 2022 онд нийт 4,346 иргэн хамрагдахаар бүртгэгдсэн ба аудитаар хийсэн дүн шинжилгээнээс харахад иргэд эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд бүрэн хамрагдаж чадаагүй байна.

Үзлэгт хамрагдахаар бүртгүүлсэн хүний тоо	4,346
Тусламж үйлчилгээний төрөл	Хүний тоо
Шинжилгээ	4,192
Хэвлийн хэт авиа	3,068
Хөхний хэт авиа (эмэгтэй)	2,054
Бамбайн хэт авиа	3,204
Улаан хоолой, ходоодны дуран	2,353
Зүрхний цахилгаан бичлэг	3,646
Цээжний рентген зураг	3,666
Эсийн шинжилгээ	736
Дүгнэлт	3,151

Эндээс харахад ихэнх иргэн шинжилгээндээ идэвхтэй хамрагдсан, улаан хоолой, ходоодны дуранд нийт бүртгүүлсэн даатгуулагчаас 2,353 (54.1 хувь) нь хамрагджээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэн эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан иргэдээс нийт 2255 өвчлөл илэрсэн, үүнээс хорт хавдрын 27 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, төрөлжсөн шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах

шинжилгээнд хамрагдаж, 16 хорт хавдар батлагдсан, нийт өвчлөлийн 421 тохиолдол нь цөсний эмгэг, 350 тохиолдол нь улаан хоолойн сөөргөөт үрэвсэл, 309 тохиолдол нь ходоодны шархны өвчлөл эзэлж байна.

Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдахаар бүртгүүлсэн 4,346 даатгуулагчийн 1,196 (27.5 хувь) нь үзлэгийн төлбөрийн 153.4 сая төгрөгийг ЭМДС-аас нэхэмжилсэн, НИЕР-д бүртгэгдээгүй (иргэн ЭМД-ын шимтгэлээ төлөөгүй, эрт илрүүлэх системийн гацалт, сүлжээний уналтын үед, иргэний хувийн мэдээлэл алдаатай тохиолдол) төлөвт орсон даатгуулагчийн тоо

Төлөв	Тоо	Хувь
Үзлэгийн төлбөрийг ЭМДС-аас нэхэмжилсэн даатгуулагчийн тоо	1,196	27.5
Үзлэг дутуу буюу 20 хоногийн хугацаанд үзлэг шинжилгээндээ бүрэн хамрагдаагүй даатгуулагчийн тоо	1,842	42.4
НИЕР-д бүртгэгдээгүй (иргэн ЭМД-ын шимтгэлээ төлөөгүй, эрт илрүүлэх системийн гацалт, сүлжээний уналтын үед, иргэний хувийн мэдээлэл алдаатай тохиолдол) төлөвт орсон даатгуулагчийн тоо	1,308	30.1
ДҮН	4,346	100

мэдээлэл алдаатай тохиолдол) төлөвт орсон 1308 даатгуулагч байгаагаас харахад аймгийн Нэгдсэн эмнэлгийн менежмент, зохион байгуулалт хангалтгүй, ЭМДС-аас санхүүжилт авч чадаагүй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлоогүй зэрэгтэй холбоотой байна.

Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдаж буй иргэдийн тоо бага байгаа, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдахаар бүртгүүлсэн иргэд бүрэн хамрагдахгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Аймгийн хэмжээний 18-аас дээш насны иргэдийн үзлэг, оношилгоог зөвхөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийж байгаагаас ачаалал, дараалал их үүсдэг;
- Ходоодны дурангийн аппарат, их эмч нэг байгаагаас дурангийн үзлэгийг 5-10 хоногийн дараа цаг өгч үзүүлдэг;
- Хөдөө сумдаас ирж үзүүлж буй иргэд богино хугацаагаар үзүүлэх зорилготой ирдэг тул оочир дарааллаас шалтгаалан олон хоногоор хүлээх боломжгүйгээс багц шинжилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй буцдаг;



Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдахаар бүртгүүлсэн 4,346 даатгуулагчийн 1,842 (42.4 хувь) нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор баталсан журмын 2.4.3⁹ үзлэгийн хоногтоо багтаан үзүүлээгүй байгаа тул цаашид тус хоногийг ажлын 20 хоног болгон өөрчлөх саналыг ЭМДЕГ-т уламжлав.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 37 их эмчээс авсан санал асуулгаар эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог чанартай хийгдэж байгаа гэж 26 (70.3 хувь) эмч үзсэн бол 10 эмч (27.0 хувь) чанаргүй хийгдэж байгаа, 1 (2.7 хувь) эмч мэдэхгүй гэж хариулснаас үзэхэд цаашид тус тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэж үзэхээр байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Дэмжих төвд эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээний талаар зөвхөн хөлтэй самбар байршуулсан, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны талаар мэдээлэл, сурталчилгааны материал байхгүй;
- Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд үзлэгийн цагийг өгдөггүйгээс оочер дараалал их;
- Эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд 20 хоногтоо багтаж үзүүлээгүй иргэдтэй холбоо барьж, хугацаанд нь багтаж үзлэгт хамруулах талаар арга хэмжээ аваагүй;
- Зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген зураг, эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, багцын дүгнэлтэд зарим хамрагдаагүй иргэнийг үзлэгт хамрагдсанаар бүртгэсэн;
- Шээсний, өтгөнд далд цус илрүүлэх зарим иргэн шинжилгээг өгөөгүй байхад өгснөөр бүртгэж, шинжилгээний хариуг гаргасан байна.

Иймд аймгийн Нэгдсэн эмнэлгээс хийсэн эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд байдалд хяналт-шинжилгээ, үнэлээг хийх зөвлөмжийг аймгийн Эрүүл мэндийн газар хүргүүлэв.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоолоор өндөр өртөгт оношилгоо шинжилгээний иргэн хариуцан төлөх төлбөрийг кассын орлоготой тулгахад 2022 онд 25 иргэний 0.4 сая төгрөгийг тушаагаагүй байхад оношилгоо, шинжилгээг хийсэн тул буруутай албан тушаалтнаар төлүүлэх зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн E-health программын шинэчлэлийг 2022 оны 12 дугаар сард хийх үеэр тохиргоо алдагдсаны улмаас төр хариуцах 87 иргэний 2.3 сая төгрөг иргэн төлсөн төлөвт шилжсэнээр бүртгэгдсэний улмаас ЭМХС-аас санхүүжилтийг дутуу авсан байна.

Аудитын явцад E-health программ дахь дээрх системийн алдааг илрүүлж, программ хөгжүүлэгч “ICT” группийн “МЕТЕКС ПЛАС” ХХК-тай холбогдон 2023.05.18-ны өдөр алдааг залруулсан нь цаашид санхүүжилтийг бүрэн авах боломжтой болсноор аудитын үр дүн гарсан байна.

Шинэ тогтолцоонд шилжсэнээр хөнгөлөлтэй эмийг жорын хүчинтэй хугацаанд дурын эмийн сангаас авдаг болсон, санхүүжилтийн хязгаар байхгүйгээс хэдийд ч хөнгөлөлттэй эмийг авах бололцоотой болсон давуу талтай байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ-ээс аудитын явцад эмийн сан, эмчээр хөнгөлөлттэй үнийн жорын тооны судалгааг 2 оноор гаргуулан авч, аудитаар ӨЭМТ, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарын бичсэн хөнгөлөлттэй жорын тоонд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

⁹ Даатгуулагчид үзүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг үзүүлж эхэлснээс дуусах хүртэл нь хуанлийн 20 хоногийн хугацаанд багтаах;
БНА-2023/19-3-ШТА-ГА



2021 он		2021 он	
Эмчийн нэр	Бичсэн жорны тоо	Эмчийн нэр	Бичсэн жорны тоо
Н.Онцгэрэл Энхбүрд	4,914	Ж.Дулмаа НЭ	867
С.Лхамдулам Оточмандал	4,460	Ц.Цэцэгмаа НЭ	426
О.Буянжаргал Оточномгон	3,036	А.Түмэндэмбэрэл НЭ	417

2022 он		2022 он	
Эмчийн нэр	Бичсэн жорны тоо	Эмчийн нэр	Бичсэн жорны тоо
Г.Дэжид Оточмандал	3,377	Ж.Дулмаа НЭ	1,092
Г.Пүрэвсүрэн Наранмандал	2,877	А.Түмэндэмбэрэл НЭ	484
Н.Онцгэрэл Энхбүрд	2,863	О.Батаа НЭ	409

Хөнгөлөлттэй эмийн жорыг иргэдэд анхан шатны ЭМБ-ийн эмч нар бичиж байгаа ба аймгийн төвийн эмийн сангуудаар хөнгөлөлттэй үнээр олгосон эмээс 2021 онд экватор, брайнакт, лориста, 2022 онд экватор, клопиденк, лориста зэрэг эм хамгийн өндөр борлуулалттай байжээ.

Харин сумдын хувьд 2021, 2022 онд Богд сум хамгийн их хөнгөлөлттэй эмийн жорыг бичсэн бол, Баацагаан сум хамгийн бага жорыг бичсэн байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ-ээс 2021 онд 2, 2022 онд 4 удаа сум, өрхийн ЭМТ-ийн нартай цахим уулзалт хийж, анхаарах асуудлыг танилцуулсан хэдий ч, хөнгөлөлттэй эмийн жорын бичилтийг анхан шатны баримт, үзлэгийн журналтай газар дээр нь тулган шалгах, аймгийн ЭМГ хамгийн их олгож байгаа эмийн талаар судалгаанд дүн шинжилгээ хийж ажиллах байдал дутагдалтай байна.

Шинэжинст сумын эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2022.06.28-ны өдрийн А/439 дүгээр захирамжаар цуцалсны улмаас тухайн сумын иргэд хөнгөлөлттэй эмийг ойролцоох сум, аймгийн төвөөс авч байгаа тул сумд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэх эмийн сангийн асуудлыг яаралтай шийдвэрлэх, цаашид эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн ЭМГ-ын хүргүүлэв.

Аудитын явцад Баянхонгор аймаг, сумын иргэдээс авсан санал асуулгаар Эрүүл мэндийн даатгалаар та авах шаардлагатай эмийнхээ үнийг хөнгөлүүлж авч чаддаг уу? гэсэн асуултад 26.4 хувь нь Тийм, 73.6 хувь нь Үгүй гэж хариулсан байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 37 эмчээс авсан судалгаагаар “Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад нэмж оруулах зайлшгүй шаардлагатай эм байна уу?” гэсэн асуултад 16 эмч үе мөчний архаг үзлэг, антибиотикийг 80 хувь хөнгөлөх, sildenafil, Визана, Пимафруци, альбендазол, биферон, форсига-10гр, салдапил болон урьдчилан сэргийлэх болон уналт таталтын эмийг нэмж оруулах шаардлагатай гэжээ.

Иймд хөнгөлөлттэй эмийн жороор бичих эмийн тоог судалгаа, өвчлөлийн тоон мэдээлэлд үндэслэн нэмэгдүүлэх асуудлыг мэргэжлийн байгууллага хийх нь зүйтэй байна.

Аудитын явцад сум, өрхийн ЭМБ-ын эмч, ажилтнуудтай цахим уулзалт хийх үеэр өмнөх жилүүдэд ковид цар тахлын үе дэх ковидоор өвчлөгсдийн оношны бүлэг (980.000 төгрөг)-ийн санхүүжилт өндөр байсан, энэ нь санхүүжилт дээр нэмэгдэж байснаас үйл ажиллагаа явуулахад хэвийн байсан бол 2023 оноос эхлэн үйл ажиллагааны зардал хүрэхгүй, санхүүгийн хүндрэл үүсэн, эрсдэлд орох, санхүүгийн алдагдал хүлээхээр байгаа тул дараах саналууд гарч байсан. Үүнд:

- Хүн ам цөөнтэй сумд нэг иргэнээр тооцсон санхүүжилт бага авч байгаагаас үйл ажиллагааны зардал нөхөхөд хүндрэлтэй, хэвтэн эмчлүүлэх тохиолдолд хоол, эмийн зардлаа нөхөж чадахгүй тохиолдолд хүрч байгаа;
- Сумдад олгож байгаа санхүүжилтийг хүн амын насжилтаар биш, хүн амын тоогоор өгөх;



- Нэг ОХБ-ээр олгож байгаа санхүүжилтийг шатлал хамаарахгүйгээр ижил санхүүжилт олгож, сумын ЭМТ-ийг дэмжих;

- Шүдний кабинеттай байхад мэргэжлийн эмч байхгүйгээс үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа, гэрээгээр эмч ажиллуулсан тохиолдолд санхүүжилт олгогддоггүй;

Аудитын явцад Богд сумын ЭМТ-өөс ирүүлсэн 2023 оны 93 дугаар албан бичгээр өдрийн эмчилгээ үзүүлэхэд 100.0 мянган төгрөгийн тариф батлагдсан ч эмийн зардал дунджаар 80.0-200.0 мянган төгрөг зарцуулдаг, хэвтэн эмчилгээний зардалд 250.0 мянган төгрөг тариф батлагдсан ч өвчнөөс шалтгаалан 200.0-3,000.0 мянган төгрөг зарцуулдаг гэж эмчлүүлэгчийн хэрэглэсэн эмийн хуудсыг ирүүлжээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 37 эмчээс авсан санал асуулгаар даатгалын гэрээнд “Амбулторын үзлэг оншилгоо шинжилгээний багцын төлбөрийг нэмэгдүүлэх, Архины хордлого, хэлбэр хүнд, хөнгөн зэрэг, B67, M54, C-44, O 23 O, H76, H90, өндөр өртөгт оншилгоо шинжилгээ (зооноз) сэргээн засах хэвтэн эмчилгээ Z50.8 Z50.9, Чихрийн шижин, ЭЭ-ний А Бүлгээр ордог онош” зэргийг нэмж оруулах шаардлагатай гэж 19 эмч хариулсан байна.

Иймд цаашид даатгалын гэрээнд нэн шаардлагатай ОХБ-ийг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор баталсан тусламж үйлчилгээний суурь өртгийн тариф, итгэлцүүрийг зах зээлийн үнэ ханштай уялдуулан шинэчлэх, нэг оношны бүлгээрх тарифийг анхан болон лавлагаа шатлалд нэг тарифаар олгох асуудлыг судлахыг ЭМДЕГ-т уламжлав.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлсэн даатгуулагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсний эцэст ЭМДС-аас ямар төлбөртэй үйлчилгээ авсан талаарх мэдээллийн е-баримтыг олгохгүй байгаа асуудлыг байгууллагын удирдлагуудад аудитын багаас тавьсаны үр дүнд хэвтэн эмчлүүлсэн иргэнд е-баримтыг олгож эхэлж, аудитын үр дүн гарсан байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 5 хувийн хэвшлийн эмнэлгийн удирдлагууд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосноор үр дүн гарсан гэж үзсэн ба, хувийн эмнэлэгт ихэвхлэн өндөр настны тэтгэвэрт гарсан ажилтнууд ажиллаж, сувилагчийн ажлын байранд ажиллах боловсон хүчин бага байгаа гэсэн мэдээллийг өгсөн, хэвтэн эмчлүүлэгсдийн дийлэнх нь малчин, өндөр настан байдаг байна. Аудитаар хувийн хэвшлийн эмнэлгүүдээс дараах саналыг гаргасныг цаашид ЭМДЕГ анхааралдаа авах нь зүйтэй байна. Үүнд:

- Сонгон шалгаруулалт явуулахдаа Улаанбаатар хотын том эмнэлгүүдтэй харьцуулалт хийж байгаагаас сонгон шалгаруулалтад тэнцээгүй;
- Хүмүүс цусны бүлгээ мэддэггүй хүндрэлтэй тул эрт илрүүлэх үзлэг оношилгоонд цусны бүлгийг тодорхойлох шинжилгээг оруулах;
- Аймгийн хэмжээнд тархины судасны бичлэг хийх аппарат нэг байж, хувийн эмнэлэгт хэвтсэн иргэн улсын эмнэлэгт хийлгэх боломжтой байхад хувийн эмнэлгийг тоног төхөөрөмжийн шаардлага хангаагүй гэж сонгон шалгаруулалтаа хассан;
- Асаргаа сувилгаа сайн тул хөнгөвчлөх эмчилгээг нэмэлт сонгон шалгаруулалтаар авах; (аймгийн Нэгдсэн эмнэлэгт хаврын туяа эмчилгээнд хамрагдсан хүн эмнэлгээс гараад хэвтэх хувийн эмнэлэг байхгүй)
- Хяналтаар хасагдсан ОХБ-ийн зардлыг 100 хувиар хасахгүй, ядаж 70 хувиар тооцож олгодог байх;
- Хувийн хэвшлийн эмнэлгүүд нийлээд эм, тарианд тендер зарладаг байх;
- Хувийн эмнэлгүүдийг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг олгох асуудлыг төрөөс бодлогоор дэмжих;



- Эрс тэс уур амьсгалтайгаас шалтгаалан бэлгийн замын халдварт өвчин, бөөр, шээс дамжуулах замын өвчин тэр дотроо эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний үрэвсэлт өвчин их тул ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолыг өөрчлөх (тогтоолыг боловсруулахдаа дулаан орны жишээнд тулгуурласан)
- 3 сар дотор зулбалтыг 1 удаагийн төрөлт гэж андуурч бичсэн;
- Хувийн эмнэлэгт хэвтсэн даатгуулагчийн шинжилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт өгдөг болгох;
- Эмэгтэйчүүдийн хувийн эмнэлэгт ЭХО-оор үзлэг хийхэд эхоний гель, нэг удаагийн үзлэгийн бээлий, бэлгэвч зэрэг нэмэлт зүйл их шаардлагатай, материалын үнэ өсч байгаа тул 250.000 төгрөгийн санхүүжилтийг цаашид нэмэгдүүлэх зэрэг саналыг өгсөн.

Иймд ЭМДЕГ-аас улсын болон хувийн хэвшлээс саналыг авч, тогтолцооны гажуудлыг засан, иргэдэд ээлтэй нөхцөл бололцоог бүрдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн ЭМБ-ыг дэмжих нь зүйтэй байна.

БҮЛЭГ Б.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭНЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ТОДОРХОЙ АХИЦ ДЭВШИЛ ГАРСАН БАЙНА.

Б2.1. Баянхонгор аймгийн хэмжээнд иргэдэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч аймгийн ЭМГ, НДХ, ЭМДХ, Нэгдсэн эмнэлгүүдэд эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, мэдээлэл сурталчилгааг хариуцан ажиллаж байгаа албан хаагчдын уялдаа холбоо хангалтгүйгээс ЭМД-ын хамрагдалт төлөвлөснөөс 2021 онд 38 хувь, 2022 онд 67 хувьтай гарчээ.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2021-2022 онд 27,600 малчин, 3,000 оюутан, 9,880 ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахаар төлөвлөснөөс 12,630 малчин, 1,419 оюутан, 6,027 иргэдийг даатгалд хамруулж, төлөвлөгөөний биелэлт 38-67 хувьтай гарчээ.

Хүснэгт 9. ЭМД-ийн хамрагдалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (хүний тоогоор)

ЭМД-д хамрагдах иргэд	2021 он			2022 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Малчин	17,300	6,117	35	10,300	6,513	63
Оюутан	1,500	680	45	1,500	739	49
Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд	5,200	2,267	44	4,680	3,760	80
ДҮН	24,000	9,064	38	16,480	11,012	67

Эх сурвалж: Баянхонгор аймгийн НДХ-ээс ирүүлсэн судалгаа

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн орон тоонд ажиллаж байгаа ЭМД-ын орлого, шимтгэлийн байцаагчийн албан тушаалын зорилгыг “ЭМД-ын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, иргэд даатгуулагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, орлогыг төлөвлөгөөг биелүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх...” гэж заасан байна. Мөн сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт аймгийн НДХ-ийн даргын тушаалаар эрүүл мэндийн орлогыг бүрдүүлсэн ажлын үр дүнг харгалзан 2021, 2022 он тус бүр 8.1 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 99 дүгээр тогтоолын 19 дүгээр хавсралтаар баталсан чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 5 дугаар зорилт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 69 дүгээр тогтоолын хавсралтаар хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтын 4 дүгээр зорилтын хүрээнд “Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зардлын гүйцэтгэлийг хангуулах, тайлагнах.....” гэж заасан байхад ЭМД-ын хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.



Иймд цаашид эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын хувь болон сангийн орлогыг хариуцан ажиллах **орон тооны ажилтныг** аймгийн ЭМДХ-т ажиллуулах, аймгийн ЭМГ-ын мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээлэл сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, аймгийн НДХ-ийн ЭМД-ын орлого, шимтгэлийн байцаагч, ЭМДХ-ийн чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод заасан нь чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж, ЭМДС-ийн орлого бүрдүүлэлт, ЭМД-д хамрагдаагүй иргэдийн хувийг багасгах талаар нэгдсэн бодлого чиглэлтэй ажиллах нь зүйтэй байна.

Баянхонгор аймаг нь ард иргэдэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хамруулах чиглэлээр дараах бодлогыг баримтлан хэрэгжүүлсэн байна.

Давхардсан тоогоор 2021 онд 357871 иргэн, 2022 онд 295984 иргэн эрүүл мэндийн хөнгөлөлттэй эмийн хөнгөлөлт оношилгоо, шинжилгээ, амбулатори, хэвтэн эмчлүүлэх, урьдчилсан сэргийлэх үзлэг, вакцинжуулалт зэрэг тусламж үйлчилгээнд хамрагдсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний өдрийн 2/9 дугаар тогтоол, 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг баталсан ба хүн амын эрүүл мэндийн чиглэлээр 2021-2022 онуудад дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Нэг. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого: Ковид-19” халдварт цар тахлын үед орон нутгийн төсөв, улсын төсөв, ЭМЯ, ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив тусламжаар 2021 онд 409-885 ор дэлгэж тусгаарлах эмнэлэг ажиллуулж, улаан бүсэд 9640 хүн хэвтэн эмчлүүлсэн, 2022 онд 1470 хүн хэвтэн эмчлүүлсэн байна.

Ковид-19” вирусийн 2021 оны халдварын эрсдэлийн салбар дундын үнэлгээг аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2 удаа хийж, өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг шуурхай төлөвлөн, бэлэн байдлыг хангаж ажилласнаар эрсдэлийн түвшнийг 60 хувиар бууруулсан. 2022 оны байдлаар Ковид-19 цар тахлын халдварын тархалт буурч, ногоон түвшинд байгаатай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийгдэх шаардлагагүй гэж үзсэн байна.

Хүснэгт 10. Ковид цар тахлын эсрэг тусламж үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо

№	Үзүүлэлт	2021 онд	2022 он
1	Ковидын-18 вакцинд хамрагдсан	142,488	1,470
2	Ковидын-19 өрхийн эмнэлгийн хяналтад гэрээг эмчлүүлсэн	7,193	2,703
3	Ковидын-19 хэвтэн эмчлүүлсэн	9,640	1,470
4	Ковид-19 сорьц авах	-	367
5	Ковид-19 сорьц шинжлэх	9,358	1,039
ДҮН		168,679	7,049

Эх сурвалж: ЭМДС-ийн судалгаа

Хоёр. Эрүүл иргэн - Ирээдүйн үнэт зүйл-аймгийн 18-аас дээш насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах.

Аймгийн нийт хүн ам 2022 онд 89975 байгаагаас хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлд тулгуурлан урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог чиглэл бүрээр зохион байгуулсан. “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд”, “Малчдын эрүүл мэндийг дэмжих”, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны Нэхэмжлэхийг хянах журам дүгээр тушаалаар батлагдсан Бүх нийтийн эрт илрүүлэг үзлэг, Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг, Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аян, Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээ, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний оношилгоо зэрэг 8 төрлийн үзлэг зохион байгуулж, 70379 иргэн буюу хүн амын 78.2 хувийг хамруулсан.



Дээрх үзлэгүүдээс 11057 өвчлөл илрүүлж, анхан шатны болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээгээр 60 хувийг эмчилгээнд хамруулсан байна.

- Үзлэгээр дараагийн шатлалд эмчлүүлэх шаардлагатай иргэдийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлгээс лавлагаа шатлалын болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт 2021 онд 1184, 2022 онд 1513 үйлчлүүлэгчийг эмнэлэгт онош тодруулах нэн яаралтай үйлчлүүлэгчийг /АМ-13А маягт/ аар шилжүүлэн, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан ажилласан байна.

Эрүүл мэндийн сайдын 2021.12.30-ны өдрийн А/813 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журам”-ын 2.1.6 д “Дараах тусламж, үйлчилгээг авах тохиолдолд үйлчлүүлэгч лавлагаа шатлалд шилжүүлэх маяггүй шууд очиж болно” гэж 12 тусламж, үйлчилгээгээр лавлагаа шатлалын эмнэлэгт үзүүлэхэд АМ-13А маягт авах шаардлагагүй байхад 2021 онд 758 хүн, 2022 онд 1019 хүнд дээрх 12 тусламж, үйлчилгээгээр эмнэлэгт өвчтөн илгээх хуудас бичсэн байна.

Харин 2023.04.12-ны өдрөөс хойш өвчтөн илгээх маягтыг E-health, E-hospital цахим программаар тухайн эмнэлэгт хийсэн оношилгоо, шинжилгээ, хийгдсэн эмчилгээ, дараагийн шатлалын эмнэлэгт ямар шалтгаанаар илгээж байгаа талаар бүрэн гүйцэд оруулан, даатгуулагчийн хурууны хээгээр баталгаажуулан илгээдэг болсон байна.

- **“Жаргалтай амьдрал төв”**-д сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, гэр бүл судлаач, нийгмийн ажилтан зэрэг мэргэжлийн баг ажиллан орон нутгийн хөрөнгө оруулалтаар 250.0 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулан архины хамаарал бүхий /донтогч-хамгийн хүнд/ 134 иргэнийг хэвтүүлэн эмчилж, хөдөө орон нутгийн 70 иргэнд өдрийн эмчилгээ нийт 204 хүнд цогц нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлж, сэтгэцийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байна. Иймд энэ үйлчилгээг ЭМДС-аас дэмжин санхүүжилтийг олгох асуудлыг судлах нь зүйтэй байна.

- **Анхан шатлалын эмнэлгүүдийн оношилгоо эмчилгээний чадамжийг сайжруулах ажлын хүрээнд** ДЭМБ-ын санхүүжилтээр Бөмбөгөр, Баянцагаан сумын эрүүл мэндийн төвүүд, 2021 оны 6 дугаар сард ЭМЯ-ны 244.6 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сум, 4 өрхийн ЭМТ мобайл технологийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж, анхан шатны эмнэлгүүд 100 хувь уг технологийг нэвтрүүлсэн. Мобайл технологийн тусламжтайгаар гэрээр, отор нүүдлээр, алслагдсан багийн 4,800 гаруй иргэдэд нарийн мэргэжлийн оношилгоо, үзлэг шинжилгээг зохион байгуулсан.

- **“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих”** арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр 4 жилээр боловсруулан, аймгийн Засаг даргын 2022 оны А/703 дугаар захирамжаар баталсан. Аймгийн хүн амын дундаж наслалт 71.28 байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.17, эмэгтэйчүүдийнх 73.21 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 5.04-өөр бага байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 9678 эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн эрсдэлийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээ үзүүлсэн.

- **“Халдварын эрсдэлгүй ирээдүй” зорилтот төсөл хэрэгжүүлэх** Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/18 дугаар “Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай” тушаалын дагуу аймгийн хэмжээнд Бэлгийн замаар дамжих халдварын чиглэлээр үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. Эрүүл мэндийн сайдын 2021.01.27-ны өдрийн А/30 дугаар тушаалын дагуу эрсдэлт бүлгийн хүн амаас эрсдэл өндөртэй иргэдийн судалгааг гарган, нийтдээ анхан шатны нэгжүүдээс 5600 иргэн БЗДХ-ын үзлэгт хамруулахаас 98.7 хувийг хамруулсан.

- **“Сурагчдын шүдний өвчлөлийг бууруулах”** чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж 2022 онд давхардсан тоогоор 11712 хүүхэд, өсвөр үеийнхэнд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ оношилгоог зохион байгуулан, сургалт мэдээллийг хүргэн ажилласан. Нийт үзлэгт хамрагдсан хүүхдийн 75 хувь



нь шүдний цооролт, шүдний гаж хөгжил, шүд чулуужих буйлны үрэвсэлт өвчлөл илэрснийг эмчилсэн.

- “Малчдын эрүүл мэндийг дэмжих” төслийн хүрээнд Австралийн элчин сайдын яамны хөрөнгө оруулалтаар аймаг, сумдын ЗДТГ-аас судалгаа авч, 2022 онд эмзэг бүлгийн 85 малчны 2022 оны эрүүл мэндийн даатгалыг төлөхөд 4.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитаар эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, хэвтэн эмчлүүлэхтэй холбоотой санал асуулгыг аймаг, сумын 1096 иргэнээс авсан ба эрүүл мэндийн даатгалын тогтолцоо 2021 оноос өөрчлөгдөж, эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлээр санхүүжилтээ авч үйлчилгээ үзүүлдэг болсон эсэх асуултад 60.0 хувь нь мэдэхгүй, 39.8 хувь нь мэдсэн гэж хариулсан, 0.2 хувь нь хариулаагүй байна.

ЭМД, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг 40.5 хувь нь олон нийтийн сүлжээнээс, 17.4 хувь нь ам дамжсан ярианаас, 12.5 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвөөс, 12.4 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс, 4.2 хувь нь ЭМДЕГ-ын албан ёсны сайт, пэйж хуудаснаас авсан бол 12.2 хувь нь мэдээллийг авдаггүй гэж хариулжээ.

ЭМД-аар ямар, ямар үйлчилгээ үнэ төлбөргүй авах талаар мэддэг үү?



Санал асуулгад оролцсон иргэдийн 73.9 хувь нь Эрүүл мэндийн даатгалаар ямар, ямар үйлчилгээ үнэ төлбөргүй авах талаар мэдэхгүй гэж хариулсан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хүртээмжийн чанарт 2.3 хувь нь “Маш сайн”, 20.9 хувь нь “Сайн”, 53.3 хувь нь “Дунд”, 23.1 хувь нь “Муу” гэж үнэлсэн байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 86.7 хувь нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өрхийн эрүүл мэндийн төв болон сумын эмнэлгээс, 10.5 хувь нь лавлагаа шатлалын эмнэлгээс, 0.5 хувь нь гаднын орноос авдаг гэж хариулсан бол “Эрүүл мэндийн даатгалаараа үйлчилгээ авахад ямар хүндрэл гардаг вэ?” гэсэн асуултад 13.2 хувь нь бүртгэлтэй холбоотой, 48.5 хувь нь мэдээлэл хангалтгүй байдагтай холбоотой, 36.7 хувь нь тухайн ЭМБ-ын зохион байгуулалттай холбоотой хүндрэл гардаг гэж хариулжээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ихэвчлэн ямар байгууллагаас авдаг вэ?



Иргэдээс авсан санал асуулгын дүнгээс харахад иргэдийн эрүүл мэндийн мэдлэг дутмаг, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний талаар мэдээ, мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх шаардлагатай тул аймгийн Засаг дарга, ЭМГ, ЭМДХ, НДХ-т тус тус зөвлөмж хүргүүлэв.

Б2.2. Аймгийн ЭМД-ын хэлтэс болон эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим программууд хоорондоо хөрвөх боломжгүй, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ байхгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8¹⁰-т заасны дагуу эрүүл мэндийн даатгалын байгууллагын хувьд <https://health.gov.mn> цахим системийг ашиглан эмнэлэг, эмийн сангуудын нэхэмжлэхийг хянадаг бөгөөд гэрээгээр эрүүл мэндийн

¹⁰ Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх; БНА-2023/19-3-ШТА-ГА



тусламж үйлчилгээг үзүүлэгч байгууллагуудын хувьд дараах программуудыг тусламж, үйлчилгээний бүртгэлд ашигладаг.

Хүснэгт 11. ЭМБ-ын ашиглаж буй программ хангамж

№	Эрүүл мэндийн ангилал	байгууллагын	Эрүүл мэндийн нэр	байгууллагын	Ашиглаж буй программ
1	Аймгийн төвийн байгууллагууд	эрүүл мэндийн	Баянхонгор аймгийн эмнэлэг	Нэгдсэн	E-health /цахим эрүүл мэндийн систем/
2	Хувийн хэвшлийн байгууллагууд	эрүүл мэндийн	Хувийн хэвшлийн 7 мэндийн байгууллагууд	эрүүл	Eclinic /эрүүл мэндийн нэгдсэн платформ/
3	Өрхийн болон сумын ЭМТ		19 сумын ЭМТ, тосгоны ЭМТ-1, 4 өрхийн эрүүл мэндийн төв		E-hospital /цахим эрүүл мэндийн систем/
4	Сувиллууд		"Шаргалжуут" ХХК, "Баян Ундрага Зэндмэнэ" ХХК		E-health Eclinic
5	Эмийн сангууд		Аймаг суманд үйл ажиллагаа явуулж буй эмийн сан -41		Orion, Маргад, Инфосистем Мах , эмийн сангийн бүртгэлийн программууд

Эх сурвалж: Аудитаар хийсэн судалгаа

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд хэрэгжиж буй E-Health программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, 2022 оны эцсийн байдлаар модуль, 460 гаруй функцийг ашиглаж байна. Үүнд: Цахим бүртгэл, Амбулаторийн үзлэг, Лабораторийн шинжилгээ, Түргэн тусламж, Яаралтай тусламж, Дүрс оношилгоо, Цус цусан бүтээгдэхүүн захиалга, зарлага, Стационарын тусламж үйлчилгээ, Хэвтүүлэх захиалга, Цахим өвчний түүх, Эм эмнэлгийн туслах материал захиалга зарлага, Иргэний эрүүл мэндийн цахим дэвтэр зэрэг нийт 12 төрлийн үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. Тус программын давуу тал:

- ✓ Үйлчлүүлэгч иргэн цаасан карт авч явах шаардлагагүй болж, эмчид үзүүлсэн тэмдэглэл, оношилгоо шинжилгээний хариу гэх мэт өвчний бүх түүх цахим хэлбэрээр хадгалагдах болсон.
- ✓ E-Health программ ашигладаг бүх шатлалын эмнэлгүүдэд тухайн иргэн үзүүлэхэд өвчний цахим түүхийг нэгдсэн баазаас харах боломжийг бүрдүүлсэн.
- ✓ Хөнгөлөлттэй эм олгох цахим жорыг зөвхөн өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч бичдэг байсан бол E-Health программ ашиглан аймгийн Нэгдсэн эмнэлгийн 41 эмч хөнгөлөлттэй эм олгох цахим жор бичих эрхтэй болсноор амбулаториор үзүүлсэн иргэдэд чирэгдэлгүй болсон.
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нэн шаардлагатай иргэдийн дунд ЭМД-ын шимтгэл төлөөгүй иргэдийг E-Health программаар шүүлт хийн ebarimt.mn апплейкшн системээр ЭМД-ын шимтгэлийн төлөлтийг хийдэг болсноор иргэдийн цаг хугацаа хэмнэсэн зэрэг ач холбогдолтой болсон байна.

Ehealth /эмнэлгийн бүртгэлийн/ программтай холбоотой үүссэн дараах хүндрэлүүд байна. Үүнд:

- Health.gov.mn программын сервер унах болон гацалт ихтэй, Ehealth /эмнэлгийн бүртгэлийн программ/ программын хөгжүүлэлт нь гүйцдэггүй, үүнээс болоод өвчний түүх, үзлэгийн хуудас бүрэн цахимжиж чадахгүй байна.
- Даатгалын сервис байнга унадгаас шалтгаалан амбулаторийн эмч нарын үзлэг, хэвтэн эмчлүүлэгч нар дээр битүүмж үүсэхгүйгээс иргэд болон албан хаагчдад чирэгдэл учирдаг.
- Эмнэлэг тусламж үйлчилгээгээ үзүүлсэн боловч, хөрвүүлэлтийн явцад программын хасагдал их гардаг.
- Тус программын шинэчлэл тухай бүрд хийгдээгүйгээс даатгалын маягтуудын зөрүүнээс хасагдал их үүсдэг.
- E-health программын шинэчлэл сайн хийдэггүй /лицензийн төлбөр гэрээний дагуу төлөгдөж байгаа/
- Сум болон өрхийн эмнэлгүүдийг холбосон нэгдсэн программ хангамж байхгүй байна.

E-hospital программтай холбоотой дараах хүндрэлүүд үүссэн байна. Үүнд: ЭМДХ болон эмнэлгүүдийн программын хөрвүүлэлт, уялдаа муугаас:

- Эмнэлгийн программаас ЭМД-ын программ руу хөрвөх явцад зөрүү их гардаг /хүний тоо зөрдөг/, 2 сард хаагдсан хүн тухайн сард орж ирэхгүй өөр саруудад орж ирдэг, халдварын бус өвчлөл хөрвөдөггүй.
- Программын санах ой хангалтгүй, хөгжүүлэх, санах ойг сайжруулах, эм сонгох хэсгийг идэвхжүүлэх, битүүмж үүсгэхгүй байх дээр анхаарах шаардлагатай байна.



- Тус программ нь H-info руу хөрвүүлэхэд нөхөж бичих зүйл ихтэй учир төвөгтэй байдаг.
- Эрүүл мэндийн байгууллагууд, ЭМД, статистикийн программуудыг нэгтгэж өгөх хэрэгтэй байна. /E-hospital, health.gov.mn, hinfo.mn/
- Эрүүл мэндийн байгууллага нь зарим оношийг хүндрэлтэй оношоор нэхэмжилдэг харин ЭМДХ-ийн программ нь үндсэн оношийг тавихыг шаарддаг үүнээс үүдэн даатгалын нэхэмжлэх зөрүүтэй юм шиг харагдах тохиолдол гардаг.

Баянхонгор аймгийн хувийн хэвшлийн эмнэлгүүд 2021 оноос эхлэн **E-CLINIC** систем ашиглалтын гэрээ байгуулан, сард лицензийн төлбөр төлдөг байна. 2023 оны 1 дүгээр сараас өвчний түүхийг цахимаар хөтлөх болсонтой холбоотой сургалт, программын шинэчлэлт хийгдэж зарим үед доголдол гарах эрсдэлтэй, 13а маягт цахимаар илгээдэг болсонтой холбоотойгоор аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгүүдтэй онлайнаар холбогдох боломж байхгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ашиглаж байгаа эрүүл мэндийн даатгалын HIS-C цахим систем нь гар ажиллагаа ихтэй, тусламж үзүүлсэн хүний тоо нэгтгэлээрээ татагддаггүй, хүний тоог гараар тоолдог, даатгал төлөлтийн мэдээ зөрдөг, татсан жагсаалтын хэсэг, нэгтгэл дүнтэй зарим тохиолдолд зөрдөг байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс “хөнгөлөлттэй эмийн цахим жор бичих эмчийн эрхийн хүсэлтийг шийдвэрлэхэд хугацаа их орж байгаа, сум болон өрхийн ЭМТ-тэй холбогдсон нэгдсэн программ хангамж байхгүй, “МЕТЕКС ПЛАС” ХХК-ийн ажилтнууд үүссэн асуудлыг хурдан хугацаанд шийдвэрлэдэггүй, утсаа авдаггүй, программын шинэчлэл удаашралтай, хөгжүүлэлт хийх үйл ажиллагаа нь хувь хүн, компаниас хараат байдаг” зэрэг тулгамдаж байгаа асуудал байгааг ирүүлсэн ба хурууны хээ уншдаггүй гэсэн асуудлыг тавьж байсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 37, хувийн эмнэлгийн 5 эмчээс авсан санал асуулгаар Нэгдсэн эмнэлгийн эмчийн 91.7 хувь, хувийн эмнэлгийн эмчийн 40 хувь нь эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ашиглаж байгаа цахим мэдээллийн системийг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Иймд цаашид эрүүл мэндийн салбарын байгууллагууд нэгдсэн цахим системд холбогдох, ашиглаж буй программын хөгжүүлэлтийг цаг тухайд нь хийх зайлшгүй шаардлагатай байна.

Иргэд амбулаторийн цагийг биеэр авахаас гадна 1800-0119 дугаар, e-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталаар дамжуулан авч байгаа нь иргэдийн цагийг хэмнэх, иргэдэд чирэгдэл учруулахгүй сайн талтай ч e-mongolia цахим порталаар амбулаторийн цаг давхардаж байгааг засах нь зүйтэй байна.

Б2.3 Даатгуулагчид орчин үеийн техник технологийг ашиглан сошиал мэдээллийн сувгаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг хүргэсэн бөгөөд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасны дагуу шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа болон Эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг сургалт, сурталчилгааны бүхий л хэлбэрийг ашиглан олон нийтэд хүргэнэ” гэж тусгаж биелэлтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар дүгнүүлсэн байна.

Мөн Эрүүл мэндийн даатгал Edaatgal гар утасны аппликейшн, 1818.mn цахим хуудасны хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд шинээр 1096 хэрэглэгч нэмэгдүүлсэн байна. Гэвч тус байгууллага нь “Тухайн аппликейшн нь байнга гацаж даатгуулагч хэрэглэхэд хүндрэлтэй байна” гэж гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тайлагнасан байна. Аудитаар 1818.mn цахим хуудсаар нэвтрэхэд “Эмнэлэг хайх” цэс ажиллахгүй, эмийн сан цэст хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эмийн сангийн мэдээлэл дутуу, зөрүүтэй байршсан байгаа тул мэдээллийг үнэн зөв оруулах шаардлагатай байна.

Иргэд, олон нийтэд 2021-2022 онд танхимаар болон цахимаар сургалт сурталчилгааны ажил, хэлэлцүүлэг, сошиал ашиглан цаг үеийн мэдээллийг хүргэн сумдын



болон багийн засаг дарга нарыг хамарсан групп чатыг нээж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тухайлбал:

- Гэрээ бүхий ЭМБ-дад тахимаар 5, Зоот ашиглан 6 удаа 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 41 байгууллагад “Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол цаашид хийж хэрэгжүүлэх бодлого шийдвэрийн талаар сургалт, хэлэлцүүлэг хийсэн.
- Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх аймгийн Засаг даргын захирамж гарсантай холбоотой Хангайн чиглэлийн 10 сум, Говийн чиглэлийн 10 сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ЭМТ-ийн дарга, нийгмийн бодлогын ажилтан, нийгмийн даатгалын байцаагч багийн Засаг дарга нарыг хамруулан 2 өдрийн сургалтыг 190 гаруй хүнийг хамруулан цахимаар зохион байгуулсан. Энэхүү чадавхжуулах сургалтыг цаашид жил бүр зохион байгуулахаар тогтжээ.
- Facebook хуудасны хандалтын тоог нэмэгдүүлж цаг үетэй холбоотой шийдвэр, мэдээ мэдээллийг Баянхонгор аймгийн зарын болон бусад олон хандалттай группт байршуулан ажиллаж байна
- ЭМБ-уудын удирдлага, нийт албан хаагчдыг хамруулсан мессенжер групп нээн мэдээллийг цаг алдалгүй солилцож байна.

Дээрх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж буй хэлбэрээс үзэхэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11¹¹ дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ-т иргэдээс 2021 онд өргөдөл 2, 2022 онд 3 өргөдөл бичгээр ирснийг хариуг өгсөн, 2022 онд 171 иргэнээс 2018-2020 оны төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн нөхөн ногдуулах хүсэлт ирүүлснийг тухай бүр нь цахимд бүртгэн шийдвэрлэжээ. Мөн 2022.10.20-ны өдрийн иргэнээс ирсэн гомдлыг шийдвэрлэж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт асуудлыг уламжилж, холбогдох буруутай албан тушаалтанд арга хэмжээ авч ажиллажээ.

Баянхонгор аймагт эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2021 онд 399 цаасаар, 2022 онд 501 өргөдөл гомдлыг цаасаар 10 өргөдөл гомдлыг Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр ирүүлсэн ба 2021 онд 100 хувь, 2022 онд 99.9 хувийн биелэлттэй байна.

БҮЛЭГ Б.3. ЭМДЕГ-ААС ТАВИХ ДОТООД АУДИТЫН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Б3.1.Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-аас хууль тогтоомж, журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн ЭМДХ-ийг 2021 онд 75 хувь, 2022 онд 50.8 хувиар үнэлжээ.

Аймгийн ИТХ-аас тус аудитын хүрээ, хамрах хугацаанд хамааралтай “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2021 онд 2 удаа үнэлсэн байна.

Хүснэгт 12. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн судалгаа

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Баталсан огноо	Тогтоолын дугаар	2021 оны үнэлгээ /2021.07.07/	2021 оны үнэлгээ /2022.02.28/
1	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого	2017-2021 он, 2022-2026 он	2017.11.29	144	67.3	91.52
2	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах	2018-2021 он	2018.12.05	127	35	92.07

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн мэдээ, тайлан

Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс үнэлгээ хийж, 2021 онд 75 хувь буюу 3.75 оноо, 2022 онд 50.8 хувь буюу 2.54 оноогоор үнэлжээ.

¹¹ Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах



Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2022 оноос аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (bayankhongor.igovernment.mn)-аар үнэлгээ хийж, аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагаанд дараах зөрчлийг илрүүлэн зөвлөмж өгчээ. Үүнд:

- Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ил тод байдлын шалгуур, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг 3 тайланг тайлагнаагүй;
- 2022 онд тусгайлан дэвшүүлсэн зорилт байхгүй;
- Баримт бичгийг боловсруулахдаа бүрдэл дутуу гаргах, ирсэн баримт бичгийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тэмдэглэл хийдэггүй;
- Цахим шилжилтийн хүрээнд e-mongolia цахим системийг нэвтрүүлсэн боловч хэрэглэж дадлагажаагүй, үйл ажиллагаандаа албаны мэйл хаяг ашигладаггүй гэжээ. Иймд цаашид аймгийн ЗДТГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлэн, үйл ажиллагааны биелэлтийг бүрэн тайлагнах нь зүйтэй байна.

Б3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд орон тооны дутагдалтайгаас холбогдох стандарт, журмын дагуу хяналт тавьж чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМБ-ууд 2021 онд 28,262.0 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 2,552.2 (9 хувь) сая төгрөг хасагдаж 25,709.8 сая, 2022 онд 34,584.2 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 3,762.3 (10.9 хувь) сая төгрөг хасагдаж 30,821.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. (Хүснэгт 4)

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрчимт эмчилгээ, Бургатай хувийн эмнэлгийн бөөрний эмгэгийн өвчтний түүхэнд эмнэл зүйн аудит хийснээс өөр хяналтыг хийгээгүй байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ нь ЭМДЕГ-ын даргын 2021.07.23-ны өдрийн 01 дүгээр удирдамжаар Баянхонгор сумын 4 ӨЭМТ-ийн гэрээний хэрэгжилтэд газар дээрх хяналт шалгалт хийж, дараах зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд:

- Чанарын хяналтын баг нь дөрвөн багц тусламж үйлчилгээ, короновирус халдварын үед гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан эсэхэд хяналт үнэлгээ хийгээгүй, чанарын багийн үйл ажиллагаа тогтмолжоогүй.
- Санамсаргүй түүврийн аргаар өдрийн эмчилгээний 3 өвчтөний мэдээлэл үзэхэд шинжилгээ бүрдүүлээгүй, илгээх бичиггүй, амин үзүүлэлт хянах хуудас бөглөөгүй
- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлтийг тогтмол дүгнээгүй
 - Гэрийн сувилгааны иж бүрдлийн цүнхэнд байх шаардлагатай багаж хэрэгслийг нэгтгэж хийгээгүй, жагсаалтын дагуу бүрдүүлээгүй
 - Сэргээн засах тусламж үйлчилгээнд хөдөлгөөн засал хийдэггүй
 - Сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэсэн боловч үр дүнг тооцож дүгнэлт хийгээгүй
 - Короновирус халдвар батлагдсан тохиолдлыг бүртгэх тогтсон нэг форматгүй, харилцах утсыг бүрэн тэмдэглээгүй, ЭМД-ын шимтгэл төлөөгүй иргэдэд эмийн багцыг олгоогүй, өөрсдөөр авхуулж эмчлэн хянасан;
 - Гэрийн тусгаарлалтын хугацаанд эхний 1-2 дахь хоногт эмийг гэрийн гаднаас өгч байсан ба 2 удаа гэрийн эргэлт хийгээгүй зэрэг зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгч ажилласан байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ-ийн даргын 2021.05.21-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулж байгаа 20 эмийн сангийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна.

Хяналт шалгалтаар ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийн хангалт 50-70 хувь, эмийн сангийн MNS: 5260-2015 стандартын хэрэгжилт 70-аас доош хувьтай шалгагдсан Ачлал, Маралжин, Арвижих, Алтан



гурван эрдэнэ, лхам эмийн сангуудад хугацаатай зөвлөмж хүргүүлж, дахин шалгах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

Харин Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022.11.04-ний өдрийн А/154 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон бөгөөд Баянхонгор аймагт хэлтсийн даргаар ахлуулан “Баян-Ундрага зэндмэнэ” рашаан сувилал, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг, Баян-Энэрэл ХХК-ийн эмнэлэг, Мандал Баянбулаг эмнэлэг, Нарбад эмнэлэг “Шаргалжуут рашаан сувилал” ХХК, Шинэ хүн эмнэлэг зэрэг газруудад хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтын үр дүнд 7 эрүүл мэндийн байгууллагын 44 оношны хамаарлын бүлэгт газар дээрх хяналтыг зохион байгуулж, 11 оношны хамаарлын бүлэг шаардлага хангаж, 33 оношны хамаарлын бүлэг шаардлага хангаагүй гэсэн дүн гарсан байна.

Хяналт шалгалтын үр дүнгээр **шаардлага хангаагүй** эрүүл мэндийн байгууллагад ямар шийдэл гаргах талаар хяналт шалгалтын тайланд тусгаагүй байгаа бөгөөд хяналтын үр нөлөөг тооцох боломжгүй байна.

“Шаргалжуут рашаан сувилал” ХХК-ийн 2022.09.02-ны өдрийн 22/129 дүгээр албан бичигтэй холбогдуулан ЭМДЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын 2022.09.16-ны өдрийн 06/4316 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Шаргалжуут рашаан сувилал” ХХК-ийн 2022 оны 8 дугаар сарын 1,639 хүний 352.9 сая төгрөгийн нэхэмжлэлээс түүвэрлэсэн 246, нэмэлт хяналт хийлгэхээр ирүүлсэн 981, хурууны хээ уншигдаагүй гэх шалтгаанаар хаагдаагүй 248, нийт 1,475 хүний өвчний түүхэд аймгийн ЭМДХ-ээс хяналт шалгалт хийжээ.

Хяналт шалгалтаар системийн хяналтаар 45 хүний 9.2 сая, түүврийн хяналтаар түүвэрлэсэн 246 хүний анхан шатны баримтад хяналт хийхэд 236 хүний 51.1 сая, нэмэлт хяналтаар 1,029 хүний 161.5 сая нийт 1,310 хүний 282.1 сая төгрөгийн хасалт хийж 329 хүний 70.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд санхүүжилт түүврээр хийх нь эрсдэлтэй нөхцөл байдал илэрч байгаа тул цаашид **рашаан сувиллын** нэхэмжлэхэд тавих хяналтыг **бүрэн хамруулж байх** эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа тул ЭМДЕГ-т санал хүргүүлж байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ нь ямар шалтгаанаар хасагдсаныг ЭМБ-уудад тухай бүр **хүргүүлээгүйгээс** тухайн ЭМБ-ууд алдаа, зөрчлөө засаж залуулахгүй байгаагаас зөрчил **давтан** гарч санхүүжилтээ бүрэн авч чадахгүйд хүрч байгаа тул аудитаар холбогдох газарт зөвлөмж хүргүүлэв.

Б.3.3 Эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад хяналт тавьж байгаа хэдий ч тусламж үйлчилгээний чанарт тавих хяналт хангалтгүй байна.

Баянхонгор аймгийн ЭМГ нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад төлөвлөгөөт үнэлгээ хийх удирдамж батлан эм ханган нийлүүлэх байгууллагад 19 заалт, эмийн санд 24 заалт бүхий шалгуур үзүүлэлтээр Монос, МЭИК, МСТНЖ-1, МСТНЖ-2 эмийн сангуудад хяналт үнэлгээ хийж үнэлгээний дүнгээр эм ханган нийлүүлэх байгууллага нь 65 хувь, эмийн сангууд 76.5 хувьтай үнэлэгдэж хугацаатай зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

ЭМГ-ын даргын 2021 оны А/126 дугаар тушаалаар баталсан хяналт үнэлгээний удирдамжийн дагуу 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн хяналт үнэлгээг баталсан удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, байгууллага бүрийг мэргэжил арга зүйгээр ханган зөвлөмж өгч ажилласан байна.

Шинэжинст сумын Жаргалант энх мөнх эмийн сангийн үйл ажиллагаанд 2022.02.10-ны өдөр хяналт үнэлгээ хийж хугацаатай албан бичиг хүргүүлж үр дүнг тооцсон, Шаргалжуут тосгоны Рашаан тун фарм, Наянбулаг ганга эмийн санд явцын үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлж ажилласан байна.



Баянхонгор аймгийн ЭМГ-ын 2022.11.21-ний өдрийн А.107 дугаар тушаалаар ЭМБ-уудын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт үнэлгээг зохион байгуулах шийдвэр гарч 19 СЭМТ, 1 ТЭМТ-ийг үнэлэхэд 1 СЭМТ 92.8 хувь буюу “Маш сайн”, 7 СЭМТ, 1 ТЭМТ 80.7-84.5 хувь буюу “Сайн”, 2 СЭМТ 70.9-77.2 хувь буюу “Хангалттай”, 3 СЭМТ 62.5-67.5 хувь буюу “Дутагдалтай” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2021 онд эрүүл ахуйн халдвар хамгаалал, эм био бэлдмэл, хүнсний чанар, стандарт, цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хэмжил зүй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлэг, 7 СЭМТ, 3 ӨЭМТ, Шинэ төв нүдний эмнэлэгт төлөвлөгөөт хяналт шалгалтууд хийсэн байна.

Мөн МХЕГ-ын хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2021 онд короновирус халдварт өвчинтэй холбоотойгоор сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэг, дархлаажуулалтын бэлэн байдал, вакцинжуулалтын үйл ажиллагаа, тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 6 удаа хийсэн байна. Тус газар татан буугдсан тул 2022 оны хяналт шалгалтын баримтыг Төрийн архивд шилжүүлсэн тул аудитад ирүүлээгүй болно.

Дээрх эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМБ-дад хяналт тавьж байгаа хэдий ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид тавих хяналт хангалтгүй байгаа тул аймгийн ЭМГ-т зөвлөмж хүргүүлэв.

Б3.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс ЭМЯ-наас 2022 оны жилийн эцэст үнэ төлбөргүй нийлүүлсэн 264.0 сая төгрөгийн хөрөнгийн эмийн хугацаа дуусаж, хөрөнгийн үр өгөөж гараагүй байна.

Баянхонгор аймгийн ЭМДХ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бие даасан цэс байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргаас бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосон байна. Үүнд:

1. Жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;
2. Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах зэрэг заалтуудыг хэрэгжүүлэх;

Баянхонгор аймгийн эрүүл мэндийн салбарын нийт 27 байгууллагын санхүүгийн тайланд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилттэй 16 байгууллагад 63.5 сая төгрөгийн 16 зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 62.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 9 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт 13. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчлийн нэгтгэл (сая төг)

№	Зөрчсөн хуулийн заалт	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн



1	15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;	2	20.6	1	0.2	1	20.4	0	-
2	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;	3	1.0	3	1.0	-	-	0	-
3	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;	10	36.5	-	-	1	36.5	9	-
4	15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	1	5.4			1	5.4		
	ДҮН	16	63.5	4	1.2	3	62.3	9	0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад хийсэн судалгаагаар Баянхонгор аймгийн 19 сумын эрүүл мэндийн төвүүдийн 2022 оны жилийн эцсийн эм, боох материалын үлдэгдэлд 131.6 сая төгрөгийн эмийн хугацаа 2023 оны 1 дүгээр улиралд дууссан, 132.4 сая төгрөгийн ремдесивер эмийн хугацаа 2 дугаар улиралд дууссан нь нийт эмийн үлдэгдлийн 40 хувийг эзэлж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” заалтыг сумын ЭМТ-үүд хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Баянхонгор аймгийн сумын эрүүл мэндийн төвүүдийн эм, боох материалын 2022.12.31-ны байдлаарх үлдэгдэл 656.8 сая төгрөг болж өмнөх оноос 348.1 сая төгрөгөөр (113 хувиар) нэмэгдсэн нь 2022 онд Эрүүл мэндийн яамнаас Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газарт 1,049.0 сая төгрөгийн эм тариа, хамгаалах хэрэгсэл үнэ төлбөргүй нийлүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

Сумын ЭМТ-ийн 2022 оны жилийн эцсийн тайлангаарх нийт эмийн үлдэгдлээс 131.6 сая төгрөгийн /20 хувь/ эм, тариа 2023 оны 1 дүгээр улиралд хугацаа дууссаны дотор 2022.11.15-нд Эрүүл мэндийн яамнаас нийлүүлсэн (нэг бүр нь 1.4 сая төгрөгийн үнэтэй) 68.4 сая төгрөгийн “Тоцилизумаб 400 мг 20мл /фл/” тариа 2023.03.01-нд хугацаа дууссан, мөн 132.4 сая төгрөгийн 2908 ширхэг “Ремдесивер” ковидын вирусны эмрэг тариа нь 2023 оны 5-7 дугаар сард хугацаа дуусахаар байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3¹², 6.4.1¹³ заалттай нийцэхгүй 264.0 сая төгрөгийн төсвийн хөрөнгийн үргүй зардал болсон байна.

Хүснэгт 14. Эм боох материалд хугацаа нь дуусах эмийн үлдэгдлийн судалгаа

(сая төг)

Байгууллагын нэр	Эм боох матетиалын үлдэгдэл 2021.12.31	Эм боох матетиалын үлдэгдэл 2022.12.31	2023.03.31-ны байдлаар хугацаа дууссан эмийн үлдэгдэл	Тоцилизумаб 400 мг 20мл /фл/		Ремдесивер	
				тоо	дүн	тоо	дүн
Баацагаан сумын ЭМТ	18.8	41.5	3.2	2	2.9	125	4.8
Баянбулаг сумын ЭМТ	3.7	6.7	6.9	3	4.3	143	6.2
Баянговь сумын ЭМТ	4.7	6.0	4.9	2	2.9	125	4.8
Баянлиг сумын ЭМТ	6.0	12.5	4.3	3	4.3	125	4.8
Баян-Овоо сумын ЭМТ	10.1	5.4	2.9	2	2.9	125	4.8
Баян-Өндөр сумын ЭМТ	6.3	13.7	4.3	3	4.3	125	4.8
Шаргалжуут тосгон ЭМТ	19.4	43.1	4.4	3	4.3	125	4.8
Баянцагаан сумын ЭМТ	-	42.4	2.9	2	2.9	125	4.8
Богд сумын ЭМТ	43.5	79.3	3.1	2	2.9	125	4.8
Бөмбөгөр сумын ЭМТ	5.8	26.8	4.3	3	4.3	125	4.8

¹² “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”,

¹³ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” БНА-2023/19-3-ШТА-ГА



Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө

Бууцагаан сумын ЭМТ	38.4	65.1	2.9	2	2.9	125	4.8
Галуут сумын ЭМТ	3.2	10.1	2.9	2	2.9	125	4.8
Гурванбулаг сумын ЭМТ	11.7	51.8	42.8	3	4.3	466	36.5
Жаргалант сумын ЭМТ	29.9	40.4	6.7	3	4.3	154	6.5
Жинст сумын ЭМТ	8.0	20.6	4.5	3	4.3	125	4.8
Заг сумын ЭМТ	8.7	14.6	11.4	2	2.9	145	5.7
Өлзийт сумын ЭМТ	30.2	48.6	5.9	1	1.4	125	4.8
Хүрээмарал сумын ЭМТ	8.3	22.0	1.8	1	1.4	125	4.8
Шинэжинст сумын ЭМТ	30.0	88.7	4.3	3	4.3	125	4.8
Эрдэнэцогт сумын ЭМТ	21.9	17.3	7.5	3	4.3	125	4.8
ДҮН	308.7	656.8	131.6	48	68.4	2,908.0	132.4

Эх сурвалж: СЭМТ-өөс авсан судалгаа

Иймд Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй нийлүүлж буй эмийн чанар, баталгаат хугацаанд онцгой анхаарах, аймаг, орон нутгаас эмийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлж төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байх зөвлөмжийн Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх саналыг ҮАГ-т уламжилж байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг төсвийн шууд захирагчийн 2021, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзсэн болно.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, 20 сумын эрүүл мэндийн төв, 4 өрхийн эмнэлэг нийт 26 байгууллага шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулсан.

Санхүүгийн тайлангийн 2021 оны аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 15 зөрчил илэрснээс 86.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 730.3 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмжийг 14 байгууллагад хүргүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 үйлчлэлд хамаарах нийт 27 байгууллагын шилэн дансанд 3023 шийдвэрийн 39,624.1 сая төгрөгийн мэдээлэл оруулахаас 62 мэдээллийн 318.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, 13 мэдээллийн 168.6 сая төгрөгийг хугацаа хоцроосон зөрчилд 1 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсний үр дүнд аймгийн Засаг даргын 2022.10.06-ны өдрийн 06 дугаар “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” албан даалгаврыг бүх шатны төсөв захирагч нарт хүргүүлсэн. Албан даалгаврын хүрээнд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 2022 оны 9-10 дугаар сард шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.11.14-ны өдрийн 7/2002 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор 2022 онд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буурсан байна.

Аудитаар нийт 301.4 сая төгрөгийн 27 зөрчил илэрсэнд холбогдох таван албан тушаалтанд 23 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн, ҮАГ-т уламжлан ЭМЯ-д нэг, ЭМДЕГ-т 10 саналыг уламжлав.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**
108 дугаар байр, Найрамдалын гудамж 1,
Номгон 1 дугаар байр, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 54101
Утас: (976) 70442878, 70442891
Цахим шуудан: info@bayankhongor.moh.gov.mn

А.23.05.19 № 444
Танай 2023.05.18 ны № 1/10

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан "Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилт, түүний үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Аудитын дүнд үндэслэн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгааг уламжилж байна. Цаашид холбогдох асуудлыг эрүүл мэндийн салбарын удирдах байгууллагын хүрээнд дөвшүүлэн шийдвэрлүүлж, үйл ажиллагаа сайжруулан ажиглах болно.

Хамтран ажилласанд баярлалаа.

УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА *Т.ХАЖИДСҮРЭН*

64.311538

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭГ**

Баянхонгор сум, Найрамдалын даатгал 108/1
Утас: (976) 7044 2888
Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn
www.ema.gov.mn

2023.05.15 № 14/91
Танай 2023.05.18 ны № 1/809

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас цахимаар ирүүлсэн "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн дүнг хүлээн зөвшөөрч байгаагаа үүгээр уламжилж байна.

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРВОН
ГҮЙЦЭТГЭГЧ *М.ОЮУНЖАРГАЛ* П.ОЮУНЖАРГАЛ

64.311538

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЦАМАГСАРЫН НЭРЭМЖИТ
НЭГДСЭН ӨМНӨЛӨГ**
103 дугаар байр, Эрх чөлөөний гудамж 1,
Номгон 1 дугаар байр, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 54101, Утас: (976) 70442543
Цахим шуудан: pe@ohf.moh.gov.mn
цахим хаяг: ohf.moh.gov.mn

2023.05.19 № 340
Танай 2023.05.18 ны № 1/211

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

"Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд санал байхгүй болно.

ЭМЧИЛГЭЭ ОРХОЛСОН
ОРЛОГЧ ДАРГА *П.АРИУНАА* П.АРИУНАА

64.311538



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2022 онд үндэслэлгүй төлөвлөсөн, аймгийн ЭМГ, НДХ, ЭМДХ, Нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн даатгалыг иргэдэд сурталчлах, орлогыг бүрдүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс ЭМД-ын хамрагдалт 2021 онд 38 хувь, 2022 онд 67 хувь, ЭМД-ын орлогын биелэлт 2021 онд 97.5 хувь, 2022 онд 60.8 хувьтай гарчээ.
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянасан боловч нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр сар бүр тайлан гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээгүй, санхүүжилтийг журамд заасан хугацаанаас хоцроож олгосон байна.
3. Баянхонгор аймгийн ЭМДХ баталсан 5 орон тоогоор ажиллаагүй, 2023 оны 5 дугаар сарын байдлаар санхүүгийн мэргэжилтэй 1 мэргэжилтэн ажиллаж байгаа нь цаашид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлийг хянахад эрсдэл үүсэхээр байна.
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэмэлт сонгон шалгаруулалтад хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүрээнд иргэдэд үзүүлэх боломжтой оношны хамаарлын бүлгийг нэмээгүйгээс иргэдэд олгох боломжтой эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж чадахгүй байна.
5. ЭМДЕГ-тай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээг тухай бүр дүгнээгүй байна.
6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор баталсан тусламж үйлчилгээний суурь өртгийн тариф, итгэлцүүрийг зах зээлийн үнэ ханштай уялдуулан шинэчлэхээр байна.
7. Баянхонгор аймгийн хэмжээнд иргэдэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа ч аймгийн ЭМГ, НДХ, ЭМДХ, Нэгдсэн эмнэлгүүдэд эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, мэдээлэл сурталчилгааг хариуцан ажиллаж байгаа албан хаагчдын уялдаа холбоо хангалтгүй байна.
8. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс төлбөрийг төрөөс хариуцах эмийн зардлын 90.8-91.3 хувь нь инсулинээс үл хамаарах чихрийн шижин өвчинд, 8.6-5.3 хувь нь хорт хавдрын өвчлөлд олгосон байна.
9. Аймгийн ЭМД-ын хэлтэс болон эрүүл мэндийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим программууд хоорондоо хөрвөх боломжгүй, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ байхгүй байна.
10. Даатгуулагчид орчин үеийн техник технологийг ашиглан сошиал мэдээллийн сувгаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг хүргэсэн бөгөөд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасны дагуу шийдвэрлэсэн байна.
11. Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, аймгийн ЭМДХ-ийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-аас хууль тогтоомж, журамд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн ЭМДХ-ийг 2021 онд 75 хувь, 2022 онд 50.8 хувиар үнэлжээ.
12. Эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад хяналт тавьж байгаа хэдий ч тусламж үйлчилгээний чанарт тавих хяналт хангалтгүй байна.
13. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс ЭМЯ-наас 2022 оны жилийн эцэст үнэ төлбөргүй нийлүүлсэн 264.0 сая төгрөгийн хөрөнгийн эмийн хугацаа дуусаж, хөрөнгийн үр өгөөж гараагүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгасан эрүүл мэндийн даатгалын хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх талаар нэгдсэн чиглэл өгч, арга зүйгээр хангаж ажиллах
2. Баянхонгор аймгийн ЭМГ, ЭМДХ, НДХ, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд ЭМД-ын шимтгэлийн төлөлт, ЭМДС-аас авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгааг хүргэх ажлыг зохион байгуулах

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

1. ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, үзлэгийн дүнд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллах
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан санхүүжилтэд тавих хяналтыг сайжруулан, улсын болон хувийн эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах
3. Аймгийн хэмжээнд дутагдалтай байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх замаар хүний нөөцийг дэмжих ажлыг зохион байгуулах
4. Баянхонгор аймгийн ЗДТГ, ЭМГ, НДХ, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд ЭМД-ын шимтгэлийн төлөлт, ЭМДС-аас авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгааг хүргэх ажлыг зохион байгуулах
5. Шинэжинст суманд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэх эмийн сангийн асуудлыг нэн даруй шийдвэрлэж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэхэд хяналт тавьж ажиллах
6. ЭМДС-аас хөнгөлөлттэй эмийн жороор хамгийн их олгож байгаа эмийн талаар судалгаанд дүн шинжилгээ хийж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ

1. Баянхонгор аймгийн ЗДТГ, ЭМГ, НДХ, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд ЭМД-ын шимтгэлийн төлөлт, ЭМДС-аас авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгааг хүргэх ажлыг зохион байгуулж, ЭМД-ын орлогын болон хамрагдалтын төлөвлөгөөг биелүүлж ажиллах
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан санхүүжилтийн шалтгаан тайлбарыг тухай бүр эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд зөвлөн туслах
3. Даатгалын гэрээний хэрэгжилтийг хууль, болон даатгалын гэрээнд заасан хугацаанд багтаан дүгнэх, хангалтгүй үнэлсэн шалгуур үзүүлэлтэд зөвлөмж хүргүүлэн, гарсан үр дүнг тооцож ажиллах
4. Эмийн сантай байгуулсан даатгалын гэрээний 2.4.12-т заасныг мөрдөж, эм худалдан авалттай холбоотой мэдээллийг харах зориулалт бүхий дэлгэцийг касс дээр байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах
5. Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс өгсөн зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлэн, үйл ажиллагааны биелэлтийг бүрэн тайлагнах



6. Эрүүл мэндийн байгууллагуудын олгосон хөнгөлөлттэй эмийн жорын бичилтийн анхан шатны баримтыг үзлэгийн журналтай газар дээр нь тулган шалгах, өндөр борлуулалттай эмд дүн шинжилгээ хийж ажиллах

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ

1. ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг иргэдийг чирэгдүүлэхгүйгээр чанартай, түргэн шуурхай хийж, үзлэг, оношилгооны үнэн зөв байдалд тавих дотоод хяналтыг сайжруулах
2. Даатгалын гэрээнд заасан оношны хамаарлын бүлгээр даатгуулагчид тусламж үйлчилгээг үзүүлэн, оношны хамаарлын бүлгийг зөв бүртгэж, анхан шатны баримт, өвчтөний түүхийг стандартын дагуу бүрэн, үнэн зөв хөтөлж, санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн нэхэмжлэх
3. Аймгийн ЭМДХ-ээс нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан шалтгаан тайлбарыг дэлгэрэнгүй авч, түүнд дүн шинжилгээ хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар бодитой арга хэмжээ авах
4. Төлбөрийг төрөөс хариуцах эмийг иргэдэд сурталчлах, ялангуяа хорт хавдрын өвчинтэй иргэдэд тусламж үйлчилгээг түлхүү хүргэхэд анхаарч ажиллах, тогтоолд заасан өвчний үед олгох эмийг иргэдэд жигд хүртээмжтэй олгох
5. Үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлээр мэргэжил дээшлүүлэх хамтарсан гэрээ байгуулсан албан хаагчийг гэрээнд заасан хугацаанд нь тогтвортой ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хохирлыг нөхөн төлүүлж байх
6. ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолын өндөр өртөгт оношилгоо шинжилгээ хийлгэсэн 25 иргэний дутуу тушаасан 0.4 сая төгрөгийн төлбөрийг холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх

ТАВ. АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ

1. Баянхонгор аймгийн ЗДТГ, ЭМГ, ЭМДХ, улсын болон хувийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд ЭМД-ын шимтгэлийн төлөлт, ЭМДС-аас авах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл, сурталчилгааг хүргэх ажлыг зохион байгуулж, ЭМД-ын орлогын болон хамрагдалтын төлөвлөгөөг биелүүлж ажиллах

ЗУРГАА. БҮХ ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД

1. Баянхонгор аймгийн ЭМДХ-ээс нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан шалтгаан тайлбарыг тухай бүр авч, хасагдлын шалтгаанд дүн шинжилгээ хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар бодитой арга хэмжээ авч ажиллах
2. Даатгалын гэрээнд заасан оношны хамаарлын бүлгээр даатгуулагчид тусламж үйлчилгээг үзүүлэн, анхан шатны баримт, өвчтөний түүхийг стандартын дагуу бүрэн, үнэн зөв хөтөлж, санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн нэхэмжлэх



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

1. Аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаас үнэ төлбөргүй нийлүүлэх шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн саналыг ЭМЯ тухай бүр аваагүй нийлүүлснээс аймгийн хэмжээнд 264.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн хугацаа нь дууссан зөрчлийг давтан гаргахгүй байх

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

1. ЭМДС-аас санхүүжилтийг журамд заасан цаг хугацаанд нь олгох, ЭМДХ-ийн чанар, төлбөрийн мэргэжилтний нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан санхүүжилтийн шалтгаан тайлбарыг тухай бүр эрүүл мэндийн байгууллагад танилцуулж, баталгаажуулан хүргүүлж байгаад хяналт тавьж ажиллах
2. ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөр хяналтын журам”-ын 4.1.1.5-д заасны дагуу түүврийн тохиолдлуудаас шалгуур хангаагүй хасагдлын хувийг тухайн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хугацаанд хамаарах нийт нэхэмжлэлийн эх олонлогт ногдуулан хасалт хийх, бараа материалын зах зээлийн үнийн өсөлтийг харгалзан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний суурь өртгийг тарифыг дахин тооцох, нэг оношны бүлгээрх тарифийг анхан болон лавлагаа шатлалд нэг тарифаар тооцох
3. Рашаан сувиллын нэхэмжлэлийг түүвэр хяналт хийлгүйгээр нийт нэхэмжилсэн дүнгээр хянаж, санхүүжилтийг олгох эрх зүйн орчныг судалж бүрдүүлэх
4. Иргэн ЭМД-ийг ямар хэлбэрээр төлснөөс үл шалтгаалан иргэний оршин суугаа харьяаллын дагуу орлогыг бүртгэдэг байх, ЭМД төлсөн даруйд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлэх
5. Баянхонгор аймгийн ЭМДХ-ийг баталсан орон тоогоор бүрэн ажиллуулах, хэлтсийн орон тоонд эрүүл мэндийн салбар, эмнэл зүйн боловсролтой хяналт тавих мэргэшсэн мэргэжилтнийг түлхүү ажиллуулах
6. ЭМДЕГ-аас нэмэлт сонгон шалгаруулалтыг зарлахдаа оношны хамаарлын бүлгийг хязгаарлахгүйгээр хөдөө, орон нутгаас иргэдэд үзүүлэх боломжтой эмчилгээ, үйлчилгээний саналын сонгон шалгаруулалтыг тухай бүрд нь шийдвэрлэж байх
7. Эрүүл мэндийн байгууллагуудад тусламж үйлчилгээнд хоорондоо уялдааг хангасан мэдээллийн цогц цахим программыг ашиглах, хөгжүүлэлтийг тухай бүр хийх
8. ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор баталсан журмын 2.4.3-т заасан хугацаанд иргэд үзлэгийн хоногтоо багтаан үзүүлж чадахгүй байгаа тул журамд заасан эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд бүрэн хамрагдах хуанлийн 20 хоног гэж заасныг ажлын 20 хоног болгон өөрчлөх
9. “Баян-Энэрэл” ББН эмнэлгээс 5 даатгуулагчид үзүүлсэн 1.4 сая, “Шинэ хүн” эмнэлгээс 8 даатгуулагчид үзүүлсэн 1.8 сая төгрөгийн нэхэмжлэлийг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн дахин хянаж шийдвэрлэх
10. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн 2021 оны 388 хүний 113.7 сая, 2022 оны 61 хүний 7.5 сая төгрөгийн санхүүжилтийн мөнгөн дүн 0 дүнтэй болсон асуудлыг хянаж, шийдвэрлэлтийг тус байгууллагад хүргүүлэх

---oOo---